

ХҮНИЙГ ХҮНДЭЛ (( ХҮНИЙГ ХҮНДЭЛ )) ХҮНИЙГ ХҮНДЭЛ ХҮНИЙГ ХҮНДЭЛ ХҮНИЙГ ХҮНДЭЛ ХҮНИЙГ ХҮНДЭЛ



# ҮҮРГЭЭ МЭД

АЛБАДАН НҮҮЛГЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ГАРЫН АВЛАГА

**ЭМНЕСТИ**  
ИНТЕРНЭШНЛ



Эмнести Интернэшнл нь хүний эрхийн ноцтой зөрчлүүдийг арилгахаар нэгдсэн 150 гаруй оронд 3 сая гаруй дэмжигч, гишүүн, идэвхтэнийг хамарсан даян дэлхийн хөдөлгөөн юм.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон бусад хүний эрхийн баримт бичгээр баталгаажсан бүх эрхийг хүн бүрт эдлүүлэхийг хүсдэг.

Бид ямар нэгэн Засгийн газар, улс төрийн үзэл суртал, шашин, эдийн засгийн ашиг сонирхлоос хараат бус бөгөөд гишүүд, дэмжигчил болон иргэдийн хандиваар санхүүждэг.

© Анхны хэвлэл 2012

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

# ГАРЧИГ

АЛБАДАН НҮҮЛГЭЛТЭЭС СЭРГИЙЛЭХ ГОЛ АЛХМУУД

1. ЭНЭ ЮУНЫ ТУХАЙ ЖУРАМ ВЭ?

2. ШААРДЛАГА ХАНГАСАН ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХ

ШААРДАГА ХАНГАСАН ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХИЙГ ХАНГАХ ТӨРИЙН ҮҮРЭГ

3. АЛБАДАН НҮҮЛГЭЛТ

АЛБАДАН НҮҮЛГЭЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

АЛБАДАН НҮҮЛГЭЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ

4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫГ МӨРДӨЖ БАЙГААГ  
БАТАЛГААЖУУЛАХ НЬ

ТЭГШ БАЙДАЛ БА ҮЛ АЛАГЧЛАХ ЯВДАЛ

НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТЭЭС ЗАЙЛСХИЙХ ЭСВЭЛ ҮР НӨЛӨӨГ НЬ БАГАСГАХ АРГА ХЭМЖЭЭГ АВАХ НЬ

ҮР БҮТЭЭЛТЭЙ ЗӨВШИЛЦӨХ НЬ

ҮР НӨЛӨӨЛЛИЙГ ҮНЭЛЭХ НЬ

НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙГ ХАНГАЛТТАЙ ХУГАЦААНЫ ӨМНӨ МЭДЭЭЛЭХ НЬ

ХУУЛЬ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ НЬ

5. ОРОН БАЙРААР ХАНГАХ БА НӨХӨН ОЛГОВОР

БҮХ АЛДАГДАЛД НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ НЬ

ӨӨРӨӨ ОРОН БАЙР ОЛЖ ЧАДАХГҮЙ ХҮМҮҮСТ БОЛОМЖИЙН ОРОН БАЙР ОЛГОХ НЬ

ШИНЭ ОРОН БАЙР, ШИЛЖИН СУУРЬШИХ ГАЗАР ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫГ ХАНГАЖ БҮЙ ЭСЭХИЙГ

БАТАЛГААЖУУЛАХ НЬ

НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТЭНД ӨРТСӨН ХҮМҮҮСИЙГ ӨӨР ОРОН БАЙРААР ХАНГАХ, ШИНЭ ГАЗАРТ

ШИЛЖИН СУУРЬШИХ БОЛОМЖУУДЫГ ҮНЭЛЭХ НЬ

ТҮР ОРОН БАЙР

6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ ЯВУУЛАХ НЬ


7. ШИНЭЭР СУУРЬШИХ ҮЙЛ ЯВЦЫГ ХЯНАХ НЬ

АШИГЛАСАН БАРИМТ БИЧИГ


ОИН.МН  
СУДАЛГААНЫ САН

# АЛБАДАН НҮҮЛГЭЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ГОЛ АЛХМУУД

## ХЭРЭВ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ БОЛ



# ЗӨВШИЛЦӨХ ҮЙЛ ЯВЦ АМЖИЛТТАЙ ДУУССАН ТОХИОЛДОЛД



ГАРЫН АВЛАГЫГ ОРОН НУТГИЙН ЗАСАГ  
ЗАХИРГАА, НИЙГМИЙН АЖИЛТНУУД, ИРГЭДИЙН  
ШААРДЛАГА ХАНГАСАН ОРОН БАЙРТАЙ БАЙХ  
ЭРХИЙГ ЭДЛҮҮЛЭХЭЭР ТӨРИЙН ӨМНӨӨС  
АЖИЛЛАЖ БҮЙ БУСАД ХҮМҮҮСИЙН ХЭРЭГЦЭЭНД  
ЗОРИУЛЖ БОЛОВСРУУЛСАН ЮМ. ГАРЫН АВЛАГА  
ШААРДЛАГА ХАНГАСАН ОРОН БАЙРТАЙ БАЙХ  
ЭРХИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН  
СТАНДАРТУУДЫГ ТУСГАСНААС ГАДНА, НҮҮЛГЭН  
ШИЛЖҮҮЛЭЛТ ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ  
ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ  
ЯВУУЛАХАД АНХААРАХ АЛХАМУУДЫГ  
ТОДОРХОЙЛСОН БОЛНО.

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

# ЭНЭ ЮУНЫ ТУХАЙ ЖУРАМ ВЭ?

1

Хүн бүр шаардлагад нийцсэн орон байртай байх эрхтэй бөгөөд улс бүрийн, орон нутгийн Засаг захиргаа энэхүү эрхийг хүндэтгэх, хамгаалах хангах ёстой. Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь албадан нүүлгэлтийг хориглосон байдаг.

**Албадан нүүлгэх гэдэг нь ямар нэгэн урьдчилсан мэдэгдэл, хууль эрх зүйн хамгаалалт, хохирлын нөхөн олговоргүйгээр, тухайн хүмүүсийг хүсээгүй байхад нь орон байрнаас нь, эсвэл эзэмшиж буй газраас нүүлгэх явдлыг хэлнэ.**

Ямар нэгэн байр орон сууцыг төлөвлөх, барихад нэн түрүүнд орон нутгийн Засаг захиргаатай тохиролцдог билээ. Түүнчлэн албадан нүүлгэлтийн хамгийн түгээмэл шалтгаан буюу дэд бүтцийг сайжруулах, хот дахин төлөвлөлт гэх мэт том хэмжээний бүтээн байгуулалтын төслүүдийг орон нутгийн Засаг захиргаатай хамтарч хийдэг. Албадан нүүлгэх шалтгаан юу ч байсан орон нутгийн Засаг захиргаа л зохион байгуулж хэрэгжүүлнэ. Тийм учраас орон нутгийн Засаг захиргааны байгууллага хүн амын шаардлагад нийцсэн орон байртай байх, албадан нүүлгэлтээс хамгаалагдах эрхийг хангахад чухал үүрэгтэй юм.

Газрыг хэрхэн ашиглах, төлөвлөх тал дээр сонирхлын зөрчилтэй байгаа тохиолдолд орон нутгийн Засаг захиргааны байгууллага төвийг сахих. Нэг талаас тухайн газар дээр амьдарч буй хүмүүсийг нүүлгэх шаардлагыг холбогдох эздээс тулгах, нөгөө талаас шинэ барилга барих газраас хүмүүсийг нь нүүлгэн шилжүүлснээр гарах хохирол, шинэ барилга ашиглалтанд орсноос үүдэх үр өгөөж зэргийг харьцуулан тооцох шаардлага тулгарч болзошгүй. Эдгээр нөхцөл байдал нь хэцүү ч, **Засаг захиргаа шийдвэрээ гаргахдаа зарчмын асуудлыг үндэслэж, аль хэдийн эрх ашиг нь хөндөгдөөд эхэлсэн хүмүүст учрах сөрөг үр дагаврыг аль болох багасгах, оролцогч талуудын эрхийг хангахад чиглэсэн байх ёстой.**

Олон тохиолдолд төрийн алба хаагч эзэмшлийн аюулгүй байдлын баталгаагүй хүмүүст /тухайлбал: бүртгэлгүй иргэд, траншейнд амьдардаг хүмүүс гэх мэт/ сөргөөр хандаж асуудлыг хүндрүүлдэг. Орон нутгийн Засаг захиргааны ажилтнууд эдгээр хүмүүст хууль хэрэгжүүлэгчийнхээ үүргээр хатуурхах, нийгмийн хог шаар гэж гадуурхах тохиолдол бий. Ийм хандлага нь ажил хайж хот суурин газар шилжиж ирэхэд, боломжийн орон байртай болох хууль эрх зүйн тусламжгүйдэх, олон жилийн турш хээл хахуульд идэгдсэн төрийн алба хаагчидын арга барил учирсан учраас баталгаагүй орон байранд амьдрах нөхцөл үүссэн гэх мэт шалтгааныг өнгөц харж, асуудлын гүнд орохгүй ч илтгэж байна.

Эзэмшлийн аюулгүй байдлын баталгаагүй хүмүүсийн хувьд тогтвортой гарц, шийдвэр гаргах нь засаг захиргааны хувьд их чухал. Төрийн оролцоо эдгээр хүмүүсийн амьжиргааг сайжруулах ёстой бөгөөд давтан эрсдэлд оруулах ёсгүй. Олон улсын хуулийн дагуу тэдгээр хүмүүс тухайн газар, эсвэл орон байр эзэмших эрхтэй, эрхгүй нүүлгэн шилжүүлэлж байгаа бол тодорхой стандартыг дагаж мөрдөх ёстой. Засаг захиргаанаас албадан нүүлгэлтэд өртөж буй хүмүүсийг шаардлага хангасан орон байраар хангаагүйгээс, тэдгээр хүмүүс ажлын байр, гэртээ зарцуулсан хөрөнгөө алдах, эмнэлэг боловсролын үйлчилгээ тасрах гэх мэт олон хохирол амсахаас гадна, улам баталгаагүй газар амьдарч, дахин дахин албадан нүүлгэлтэнд өртөх магадлал нэмэгдэх болно.

Энэхүү гарын авлагад албадан нүүлгэхээс урьдчилан сэргийлэх, шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хангахад орон нутгийн Засаг захиргааны зүгээс авч хэрэгжүүлэх зайлшгүй алхмуудын талаар тайлбарлалаа.

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

# ШААРДЛАГА ХАНГАСАН ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХ

2

«ШААРДЛАГА ХАНГАСАН ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХИЙГ ХЭН НЭГЭН ХҮНИЙГ ТОЛГОЙ ХОРГОДОХ ОРОМЖООР ХАНГАХ, ЭСВЭЛ ӨМЧ ГЭСЭН ЯВЦУУ, ХЯЗГААРЛАСАН УТГААР ОЙЛГОХ ЁСГҮЙ ЮМ. ХАРИН ЭНЭ НЬ ХҮН АЮУЛГҮЙ, ТАЙВАН, НЭР ХҮНДЭЭ ХАМГААЛАХ БОЛОЛЦООТОЙ АМЬДРАХ ЭРХИЙГ ХЭЛНЭ».

НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын асуудал эрхэлсэн хороо, Ерөнхий Зөвлөмж № 4: Шаардлага хангасан орон байртай байх эрх, 1991 оны 12 сарын 13, 7 дугаар зүйл

Бүх улсын Засгийн газар шаардлага хангасан орон байртай байх эрхийг хангасан нэг буюу түүнээс дээш тооны олон улсын хүний эрхийн гэрээ, пактад нэгдсэн байдаг.

Олон улсын эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухайн олон улсын Пакт нь шаардлага хангасан орон байртай байх эрхийг баталгаажуулах гол баримт бичиг юм. Уг пактын 11.1-р зүйлд: гишүүн орнууд хүн болгон хувьдаа болон гэр бүлтэйгээ чанартай амьдрах эрхтэй бөгөөд үүнд хангалттай хувцас хунар, хоол хүнс, гэр орон багтах бөгөөд амьжиргааны чанараа байнга дээшлүүлэх эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Гишүүн орнууд нь энэхүү эрхийг бодит байдал болгохын төлөө тодорхой алхмуудыг хэрэгжүүлэх бөгөөд үүнд чөлөөт сонголт дээр үндэслэсэн олон улсын хамтын ажиллагаа чухал үүрэгтэй гэдгийг ойлгох хэрэгтэй” гэж заажээ.

НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын асуудал эрхэлсэн хороо нь энэхүү олон улсын Пактын утга санааг тайлбарлах, гишүүн орнуудын Пактын хэрэгжилтийг хянах зорилготой хараат бус шинжээчдийн байгууллага юм. Тус хороо Ерөнхий Зөвлөмж гэдэг баримт бичгээр дамжуулан Пактын хүний эрхийн талаарх үзэл санааны тайлбарыг өгдөг. Шаардлага хангасан орон байртай байх эрх, түүнтэй холбоотой төрийн үүргийн талаарх тайлбарыг Ерөнхий Зөвлөмж № 4 (Шаардлага хангасан орон байртай байх эрхийн талаар), Ерөнхий Зөвлөмж № 7 (Албадан нүүлгэлтийн талаар) -д тусгасан байна.

Шаардлага хангасан орон байртай байх эрхийг Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах олон улсын конвенц гэх мэт олон улсын болон бүсийн хүний эрхийн баримт бичгүүдээр хамгаалсан байдаг.

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА БҮР ОЛОН УЛСЫН ӨМНӨ ХҮЛЭЭСЭН ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭХ ЁСТОЙ

Аль нэгэн улс орон олон улсын гэрээ конвенцид нэгдэж орсноороо тэрхүү гэрээ конвенцид заагдсан үүргийг өөрийн улсдаа хэрэгжүүлэх эрх зүйн хариуцлага хүлээж байна гэсэн үг юм. Хэрэв төрийн аль нэг шатны /төвийн, орон нутгийн/ байгууллага /хувь хүн эсвэл байгууллага/ олон улсын өмнө хүлээсэн үүргээ зөрчвөл хариуцлагыг төр үүрэх ёстой. Энэ зарчим төрийн өмнөөс ажиллаж байгаа хүн бүрт хамаатай. Олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүйгээ тухайн улсад мөрдөгддөг хуулиар хаацайлж болохгүй. Жишээ нь, тухайн улс орон нутгийн өөрөө удирдах тогтолцоотой учраас шаардлага хангасан орон байртай байх эрхийг зөрчиж буй орон нутгийн байгууллагуудын үйл ажиллагааны төлөө хариуцлага хүлээхгүй гэж мэдэгдэх эрх төрд байхгүй.

Тийм учраас тухайн улсын хууль эрх зүйн тогтолцоо ямраас, төвийн болон орон нутгийн засаг захиргаа хэрхэн үүрэг хариуцлагатай оролцдогоос үл хамааран шаардлага хангасан орон байртай байх эрхийг хангах олон улсын хүний эрхийн стандартыг аль нэгэн төрийн алба хаагч, эсвэл төрийн шийдвэр биелүүлэгч зөрчих аваас, олон улсын хууль зөрчсөн хариуцлагыг төр хүлээх болно.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## ШААРДАГА ХАНГАСАН ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХИЙГ ХАНГАХ ТӨРИЙН ҮҮРЭГ

Төр шаардлага хангасан орон байртай байх эрхийг хүндэтгэж, хамгаалж, хангах үүрэгтэй.

Шаардлага хангасан орон байртай байх эрхийг хүндэтгэхийн тулд, төр хүмүүсийн орон байрны асуудалд тодорхойгүйгээр оролцох ёсгүй бөгөөд албадан нүүлгэхийг хориглоно.

Төрийн алба хаагч хүмүүсийн орон байрны асуудалд гуравдагч этгээд /газар эзэмшигч, компаниуд/ оролцохоос сэргийлж хамгаалах ёстой.

Албадан нүүлгэх нь шаардлага хангасан орон байртай байх эрхийн зөрчил бөгөөд аль болох урьдчилан сэргийлж, үндэсний хууль тогтоомжуудаар хориглох хэрэгтэй. Албадан нүүлгэхийг хориглосон, газар эзэмшигчдийн ялгаварлан гадуурхах боломжийг хаасан, түрээс, орон байрны нөхцлийг зохицуулсан хуулийг төрөөс баталсан байх ёстой.

Боломжтой хөрөнгө санхүүгийн хүрээнд хүн бүрийн орон байр, амьжиргааны нөхцлийг сайжруулахад чиглэсэн тодорхой, зорилготой алхмуудыг төрөөс аль болох хурдан хэрэгжүүлвэл зохино.

Олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд хүн бүр шаардлага хангасан орон байртай байх эрхээ эдлэх хууль эрх зүйн, захиргааны, төсвийн, шүүхийн, сурталчилгааны гэх мэт шаардлагатай арга хэмжээг төрөөс авч хэрэгжүүлэх ёстой. Бодлого, хөтөлбөрүүдийг хүн бүр орон байраар хангагдах боломжтойгоор боловсруулж хэрэгжүүлэх ёстой бөгөөд улсын хэмжээнд орон байрны нөхцлийг сайжруулахад давхар чиглэх ёстой.

Хамгийн багадаа хүн бүр ердийн орон байраар хангагдах боломж бүрдүүлэхийн төлөө төр ажиллах ёстой бөгөөд орон гэргүйдэн тэнүүчлэх үзэгдлийг шийдвэрлэхэд хүчин чармайлт гаргах ёстой. Ажил үүргээ гүйцэтгэх явцдаа төрийн алба хаагчид хамгийн эмзэг бүлгийн хүмүүсийг анхааран хөрөнгө төсөв хуваарилах, тэдний амьдралд нь нөлөөлөхүйц шийдвэрийг гаргахдаа тэдгээр хүмүүсийг оролцуулж, санал бодлыг тусгах хэрэгтэй. Хэрэв энэ бүх эрх зөрчигдвөл засч залруулах арга хэмжээг бас авах шаардлагатай.

## ЗАСГИЙН ГАЗАР ДАРААХ АРГА ХЭМЖЭЭГ АВАХ ЁСТОЙ

- ✓ Орон байраар хангагдах эрхийг хуулиар хамгаалагдсан эрх гэдгийг зөвшөөрч, маргаан шүүхээр шийдвэрлэгдэх байдлыг хангах
- ✓ Хүн бүр оршин суух наад захын баталгаатай, албадан нүүлгэн шилжүүлэлтээс хамгаалагдсан байхыг баталгаажуулах
- ✓ Албадан нүүлгэх хориглосон, аргагүй тохиолдолд баримтлах журмуудыг тодорхойлсон хуулийг баталж, мөрдөх
- ✓ Орон байраар хангахдаа арьс өнгөөр, эсвэл эмэгтэйчүүдийг гадуурхсан байдлыг хориглож, тухайн зөрчлийг шийдвэрлэх
- ✓ Улс орны хэмжээнд орон байрны асуудалд байнгын хяналт тавих механизм бүрдүүлэх. Энэ механизм оршин суух наад захын баталгаагүй хүмүүс, орон гэргүй, баталгаагүй орон сууцанд амьдарч буй хүмүүс, орон байраар хангагдах эрхээ эдлэж чадахгүй нийгмийн бүлгүүдийг тодорхойлох ёстой юм. Алдаа, оноогоо мэдэхийн тулд Засгийн газар холбогдох мэдээллийг байнга шинэчилж, баримтын дагуу үйл ажиллагаагаа төлөвлөх ёстой.
- ✓ Орон байртай холбоотой бүх хөтөлбөр, тэдгээрийн санхүүжилт нь хамгийн эмзэг, хохирч буй хүмүүсийг чиглэх шаардлагыг баталгаажуулах
- ✓ Хүн бүрийг орон байраар хангахын тулд барилгажуулалт, төлөвлөлт, бүсчлэх дүрэм журмыг ядуу хүмүүст орон байр барих, эсвэл сэлбэн засварлах боломж аль болох бүрдүүлэх маягаар боловсрогдож, нэмэлт өөрчлөлт хийх
- ✓ Хүмүүст өөрсдийнх нь амьдралд нөлөөлөх шийдвэрийг гаргахад оролцох, санал бодлоо хуваалцах боломж бүрдүүлэх

- ✓ Барилгын материалын үнэ боломжийн байхад анхаарах, ялангуяа ядуу хүмүүс байр барих явдлыг дэмжих
- ✓ Түрээс зэрэг бусад байртай холбоотой үнийн зохицуулалтыг хийж, түрээс, моргэйжийн үнэ нэмэгдэснээр хүмүүс бусад хэрэгцээгээ хангахад учрах хүндрэл учирлах байдлыг багасгахад анхаарах
- ✓ Хүн бүрийг ердийн орон сууцаар хангахад чиглэсэн орон сууцжуулах бодлогыг баталж, орон байрын нөхцлийг байнга дээшлүүлэхэд чиглэсэн цаг хугацаатай зорилтуудыг дэвшүүлж, эмзэг бүлгийнхэн гэх мэт нийгмийн олон давхаргын хүмүүсийн оролцоог хангах
- ✓ Олон улсын стандартын дагуу “баталгаатай” орон сууц гэж юуг тодорхойлох талаар стандарт боловсруулж, хүн оршин суух нөхцөл, байршил, үйлчилгээний боломж, барилга байшин, дэд бүтцийн стандартыг мөрдөх
- ✓ Төвийн болон орон нутгийн түвшинд олон улсын өмнө хүлээсэн үүргийн дагуу үйл ажиллагаагаа явуулж буй эсэхэд хяналт тавих үр дүнтэй механизм бүрдүүлэх
- ✓ Орон байраар хангагдах эрх нь зөрчигдсөн бүх хүнийг асуудлыг шийдвэрлэж, шүүхээр шийдвэрлүүлэх гэх мэт зохистой арга хэмжээг авах

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

# АЛБАДАН НҮҮЛГЭЛТ

«АЛБАДАН НҮҮЛГЭЛТ НЬ ТЭГШ БУС БАЙДАЛ, НИЙГМИЙН ХЯМРАЛ, САЛАН ТУСГААРЛАХ ҮЗЭЛ ЗЭРГИЙГ ДЭВЭРГЭДЭГ БӨГӨӨД ХАМГИЙН ЯДУУ, ЭМЗЭГ БҮЛГИЙН ХҮМҮҮС, ЯЛАНГУЯА ЭМЭГТЭЙЧҮҮД, ХҮҮХДҮҮД, ҮНДЭСНИЙ ЦӨӨНХ, УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХ АШГИЙГ ХӨНДДӨГ».

Хөгжилд чиглэсэн нүүлгэн шилжүүлэлтийн талаарх НҮБ-ын Суурь зарчим ба журам, 7 дугаар зүйл

3

## АЛБАДАН НҮҮЛГЭЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

Албадан нүүлгэх гэдэг нь хүмүүсийг хүсээгүй байхад, ямар нэгэн хууль эрх зүйн болон бусад хамгаалалтгүйгээр амьдарч буй газар буюу орон байрнаас нь нүүлгэхийг хэлнэ. НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын асуудал эрхэлсэн хорооноос албадан нүүлгэхийг олон улсын Пактын үзэл санаатай нийцэхгүй гэж мэдэгдсэн бөгөөд төр албадан нүүлгэхээс аль болох зайлсхийж, албадан нүүлгэлтийг гүйцэтгэж буй төрийн алба хаагч, гуравдагч этгээдийн харилцааг зохицуулсан хууль үйлчилж байхад анхаарах ёстой” гэжээ.

**Орон байр шаардлага хангаж байгаа эсэхийг тодорхойлоход эзэмшлийн баталгаа чухал үүрэгтэй** гэж хорооноос онцлон заасны зэрэгцээ “Эзэмшлийн баталгаа нь олон төрөл хэлбэртэй бөгөөд үүнд улсын болон хувийн орон сууцны түрээс, хоршооллын байр, эзэмших, ажил эрхлэх, онцгой байдлын үед ашиглах байр, газар болон өмчийн ашиглалт гэх мэт орно. Ямар байдлаар оршин сууж байгаагаас үл хамааран, хүн бүр эзэмшлийн баталгаатай байх ёстой бөгөөд үүнд албадан нүүлгэлт, хүчирхийлэл, бусад аюулаас хамгаалах хууль эрх зүйн орчин орно. Гишүүн орнууд одоогийн байдлаар эзэмшлийн баталгаа нь хангагдаагүй байгаа хүмүүс, өрхийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа яаралтай хэрэгжүүлэх ёстой бөгөөд энэ үйл ажиллагаанд эрх ашиг нь зөрчигдөж буй хүмүүсийн оролцоо, санал шүүмжийг тусгах ёстой” гэж мэдэгджээ.

Түүнчлэн НҮБ-ын Хүний эрхийн хорооноос албадан нүүлгэх нь Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 17 дугаар зүйлтэй зөрчилдөж байна гэж үзжээ. Уг пактаар хүний хувийн хэрэг, гэр бүл, орон гэрийг албадлагаар, эсвэл хууль бусаар нэгжих, нэвтрэхийг хориглодог билээ.

Албадан нүүлгэх нь Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах олон улсын конвенц, Хүүхдийн эрхийг хамгаалах конвенц, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах олон улсын конвенцийн үзэл санааны эсрэг байгаа юм. НҮБ-ын Эрүүдэн шүүхтэй тэмцэх хороо Югославын Хажрич Дзенайловын хэргээр жишээлэн зарим үед албадан нүүлгэх нь харгис, хүнлэг бус, нэр хүндэд халдсан шийтгэл болж хувирч болзошгүй бөгөөд Конвенцийн 16 дугаар зүйлийг зөрчиж байна гэж мэдэгджээ.

**НҮБ-ын Хүний эрхийн комисс албадан нүүлгэлт нь олон төрлийн хүний эрхийн тэр тусмаа шаардлага хангасан орон байртай байх эрхийг бүдүүлгээр зөрчиж байна гэж үзжээ.**

Шаардага хангасан орон байртай байх эрхийн талаархи НҮБ-ын тусгай төлөөлөгч нь засгийн газруудад мэдээлэх, зөвлөх, мэргэжлийн туслалцаа үзүүлэх үүрэгтэй бөгөөд “Хөгжилд чиглэсэн нүүлгэн шилжүүлэлтийн талаарх НҮБ-ын Суурь зарчим ба журам”-ыг боловсруулсан юм. Энэ журам нь албадан нүүлгэхтэй холбоотой стандарт, хууль зүйн орчинг судалж багтаасан байна. Мөн Олон улсын хүний эрхийн хуулийн дагуу нүүлгэхийн өмнө, явцад, дараа нь ямар алхмуудыг авч хэрэгжүүлэх талаар нарийвчилсан мэдээллийг өгчээ. Хэдийгээр Суурь зарчим нь маш олон хүн хамруулсан томоохон хөгжлийн төслүүдээс шалтгаалж үүсдэг нүүлгэн шилжүүлэлтийн асуудлыг түлхүү авч үзсэн болов ч, бүх төрлийн нүүлгэн шилжүүлэлтийн үед ашиглаж болохуйц билээ.

# АЛБАДАН НҮҮЛГЭЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ

Олон улсын хуулийн дагуу албадан нүүлгэлт нь тухайн арга хэмжээнд нэрвэгдэж буй хүмүүстэй зөвлөлдөж, зохистой бүх арга хэмжээг авсны дараа үлдэх хамгийн сүүлчийн шийдвэр болох ёстой. Албадан нүүлгэлтэнд өртөж буй хүмүүсийн эрх ашгийг хамгаалах, хууль эрх зүйн зохицуулалт хийгдэхээс өмнө албадан нүүлгэж болохгүй. Хамгаалах арга хэмжээнд дараах шаардлагууд багтана:

- Нэрвэгдэж буй хүн амыг зөвлөлдөх, санал бодлоо илэрхийлэх боломжоор хангах
- Албан нүүлгэлт болохоос хангалттай хугацааны өмнөөс мэдээлэх
- Албадан нүүлгэлтийн тухай ерөнхий мэдээлэл, тухайн хүмүүсийн газар, эсвэл орон байрыг ямар зориулалтаар ашиглах тухай мэдэгдлийг хангалттай цаг хугацааны өмнө түгээх
- Албадан нүүлгэлтийн үед төрийн алба хаагч эсвэл тэдний төлөөлөгчид газар дээр нь ажиллах
- Албадан нүүлгэлтийг зохион байгуулж буй хүн болгон биеийн байцаалттай байх
- Албадан нүүлгэлтийг цаг агаарын тохиромжгүй үед эсвэл шөнийн цагаар хийхээс татгалзах
- Хууль эрх зүйн шийдлүүд тогтоох
- Хууль эрх зүйн туслалцаа шаардлагатай хүмүүст үйлчилгээ туслалцааг үзүүлж, шүүхээр шийдвэрлүүлэх

Нүүлгэн шилжүүлэлтээс үүдэн хэн нэгэн хүн орон гэргүүдэх, эсвэл хүний эрхийн бусад зөрчилд өртөх магадлал үүсгэхгүйн төлөө хүчин чармайлт тавих хэрэгтэй. Хүмүүс өөрийн алдсан бүхэндээ нөхөн төлбөр авах ёстой бөгөөд өөрсдөө орон байр авах боломжгүй хүмүүст төрөөс орон байр олгоно.

Нөхөн олговор, өөр газар нүүж суурьших бололцоо, орон байр нүүлгэн шилжүүлэлтээс өмнө олгох ёстой. Нүүлгэн шилжүүлэхэд холбогдох арга хэмжээ буюу орон сууц барих, ус, цахилгаан, ариун цэврийн байгууламж, сургууль, зам, газрын хуваарилалт гэх мэт асуудлыг олон улсын хүний эрхийн стандартын дагуу шийдвэрлэсэн байх ёстой.

Албадан нүүлгэлтэд өртөж буй хүмүүс тухайн орон байр, газрыг түрээсэлж байсан, эсвэл өмчилж байсан зэргээс үл хамааран эдгээр шаардлагыг ямар ч албадан нүүлгэлтийн үед хангах ёстой.

**Төрийн албан хаагчид нь шүүхийн шийдвэр гүйцэтгэгчэд ч бай, эсвэл хувиараа бизнес эрхлэгчид ч бай, албадан нүүлгэхдээ хамгаалалтын арга хэмжээ авч буй эсэхэд хяналт тавих ёстой бөгөөд хамгаалалтын арга хэмжээ байхгүй тохиолдолд нүүлгэлтэнд өртөж буй хохирогчдод үр дүнтэй шийдлүүдийг олоход нь туслах ёстой.**

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн асуудал эрхэлсэн НҮБ-ын хорооноос албадан нүүлгэхийг хорьсон хууль тогтоомжийг Засгийн газрууд батлан "а/ тухайн барилга, газар дээр амьдарч байсан хүмүүсийн эзэмшлийн баталгааг хангах, б/ Пактын үзэл санаатай нэг байх, в/ албадан нүүлгэлтийг хатуу хянаж ажиллах арга хэмжээ тусгасан байх ёстой. Хууль тогтоомж нь төрийн өмнөөс албадан нүүлгэлтийг зохион байгуулж, хэрэгжүүлж буй бүх албан хаагчдад үйлчилж байх ёстой" гэжээ. НҮБ-ын хороо "Гишүүн орнууд шаардлага хангасан орон байртай байх эрхийг хангахад чиглэсэн хууль тогтоомжуудыг эргэн харж, пактын үзэл санаатай зөрчилдөж буй зүйл заалтуудыг шинэчлэх, эсвэл хүчингүй болгоход анхаарч ажиллах хэрэгтэй" гэж заасан байна.

Олон улсын хүний эрхийн тухай хуулинд албадан нүүлгэх тохиолдлыг болохуйц тодорхой зааж өгөх бөгөөд үүнд хүмүүс түрээсийн төлбөрөө удаан хугацааны туршид төлөөгүй, эсвэл тухайн газрыг чөлөөлснөөр нийгэмд ашигтай нөхцөл үүсэж байгаа тохиолдолд албадан нүүлгэж гэжээ. Олон улсын хүний эрхийн стандарт, хуулийн дагуу хийгдэж буй нүүлгэн шилжүүлэлтийг албадан нүүлгэлт гэж үзэхгүй. Хэдийгээр хүч хэрэглэх явдлыг аль болох тэвчих ёстой ч, олон улсын стандарт, хуулийн дагуу гүйцэтгэж буй л бол, хүчээр хийж буй нүүлгэн шилжүүлэлт бүрийг албадан гэж тооцож болохгүй. Хамгийн сүүлчийн, хэрэглэхээс өөр аргагүй үед л хүч хэрэглэх бөгөөд, энэ тохиолдолд ашигласан хүч нь шалтгаантай, тэнцвэртэй байх ёстой. Хэрэв төрөөс хууль эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлж, зохицуулж чадвал, нүүлгэн шилжүүлэлт нь албадан болтлоо газар авах ёсгүй билээ.

# НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫГ МӨРДӨХ БАЙГААГ БАТАЛГААЖУУЛАХ НЬ

«Төрөөс нүүлгэн шилжүүлэлт зөвхөн онцгой тохиолдолд хийгдэж буй эсэхийг баталжуулах ёстой. Нүүлгэн шилжүүлэлт нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн олон эрхийг зөрчдөг байгаа учраас энэ нь зайлшгүй шаардлагатай гэдгийг батлах бүрэн нотолгоо хэрэгтэй».

Хөгжилд чиглэсэн нүүлгэн шилжүүлэлтийн талаарх НҮБ-ын Суурь зарчим ба журам, 21 дүгээр зүйл

## ТЭГШ БАЙДАЛ БА ҮЛ АЛАГЧЛАХ ЯВДАЛ

Нүүлгэн шилжүүлэлт болон түүнтэй холбоотой үйл явцад тухайлбал шинэ газар шилжин суурьших гэх мэт ямар нэгэн ялгаварлан гадуурхалт, жендэрийн тэгш бус байдалд шууд буюу шууд бусаар нөлөөлөх, эсвэл дэвэргэх нөхцлийг бүрдүүлэхгүй байхад засаг захиргаа анхаарах шаардлагатай.

Нүүлгэн шилжүүлэлт хийхээс өөр аргагүй тохиолдолд нүүлгэн шилжүүлэлтэнд өртөх өндөр магадлалтай, эсвэл байнга нүүлгэн шилжүүлэлтэнд өртдөг хүн амын бүлэг бий эсэхийг судлах ёстой. Жишээ нь, зарим үндэсний цөөнх бүлгүүд албан бусаар оршин суудаг газар, эсвэл байнга ялгаварлан гадуурхалтад өртдөг эзэмшлийн баталгаагүй нийгмийн бүлгүүд байж болно. Ийм тохиолдолд засаг захиргааны зүгээс суурь шалтгааныг нь тогтоож, хууль эсвэл бодлогын хүрээнд алдаа байвал засаж залруулан, тухайн бүлэгт эзэмшлийн баталгаа гаргаж, ялгаварлан гадуурхалтыг зогсооход чиглэсэн арга хэмжээг авах хэрэгтэй.

Орон нутгийн болон засаг захиргааны бусад нэгжүүд нүүлгэн шилжүүлэлтийг зарчмаар, жендэрийн тэгш байдлыг дэмжих замаар зохион байгуулах ёстой. Хүн болгон ямар нэгэн алагчлалгүйгээр зөвлөгөө, хууль эрх зүйн үйлчилгээ, нөхөн олговор, шинэ газар шилжин суурьших туслалцаа авах ёстой. Олон улсын хүний эрхийн хуулийн дагуу ямарваа хүнийг арьс өнгө, үндэс угсаа, үндэсний цөөнх эсвэл уугуул иргэний байдал, хүйс, шашин шүтлэг, хэл, үндэсний болон нийгмийн гарал үүсэл, улс төрийн үзэл бодол, гэр бүлийн эсвэл төрсний байдал, бэлгийн чиг хандлага, жендэрийн тодорхойлолт, өмчийн байдал, оршин суугаа газар, эдийн засаг нийгмийн байдал, нас, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдлаар ялгаварлан гадуурхахыг хатуу хориглодог.

Ямар нэгэн шалтгаанаар нүүлгэн шилжүүлэлтийн асуудалд оролцоход хүндрэлтэй бүлгүүдэд хүрч ажиллах талаар засаг захиргаанаас илүү их анхаарах хэрэгтэй /ийм бүлгүүдэд эмэгтэйчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, үндэсний цөөнхийн төлөөлөл багтана/. Эдгээр бүлэгт хүрч ажиллахын тулд засаг захиргааны зүгээс тусгайлсан уулзалт гэх мэт болох үйл явцын талаар мэдээлэл өгөх үйл ажиллагаа зохион байгуулан тэдгээр хүмүүсийн дэмжлэг, оролцоог хангахыг чухалчлах ёстой.

Нүүлгэн шилжүүлэлтийн улмаас шинэ орон байр, эсвэл шинэ газар шилжин сууршсан байгаа тохиолдолд тухайн объект нь эмзэг бүлгийн хүн амын тусгайлсан хэрэгцээг хангахуйц байхад засаг захиргааны зүгээс анхаарах шаардлагатай. Шинээр шилжин суурьших газартай холбоотой ямар нэгэн гэрээ, өмчийн эрх зэргийг тэгш, үл ялгаварлах байдлыг дэмжихээр зохицуулна /жишээ нь, эмэгтэйчүүд тэгш эрхтэйгээр үр ашиг хүртэнэ гэх мэт/. Түүнчлэн шинээр шилжин суурьших газрыг оноохдоо ямар нэгэн ялгаварлан гадуурхалтыг дэвэргэх, арьс өнгөөр тусгаарлах байдлыг үүсгэхээс сэргийлэх хэрэгтэй.

## НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТЭЭС ЗАЙЛСХИЙХ ЭСВЭЛ ҮР НӨЛӨӨГ НЬ БАГАСГАХ АРГА ХЭМЖЭЭГ АВАХ НЬ

Нүүлгэн шилжүүлэлт нь хувь хүн, нийгмийн бүлгийн амьдралын хэв маягийг эвдэхэд хүргэдэг. Хүн орон байраа алдсанаар дассан сурсан орчин, хөршүүдээ давхар алдах бөгөөд ажил хийх боломж, боловсрол, эрүүл мэнд бусад нийгмийн үйлчилгээ авахад чирэгдэл учирна.

Тиймээс, засаг захиргааны зүгээс нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийж, эсвэл нөлөөг нь аль болох багасгах хүчин чармайлт тавих ёстой. Нүүлгэн шилжүүлэлтэд өртөж буй бүх хүнтэй зөвлөлдөж, бусад боломжтой аргуудыг судлах ёстой. Жишээ нь, хэн нэгэн хүнийг түрээсийн төлбөрөө төлөөгүйгээс албадан нүүлгэх гэж байгаа аваас, тэр хүнтэй зөвшилцсөнөөр түрээсээ төлөх арай урт хугацааг тохирч болно. Хүмүүс аюултай нөхцөлд байгаа учраас нүүлгэн шилжүүлэх тохиолдолд орон байрыг нь нураахаас өмнө засаж сайжруулах боломжтой эсэхийг судалж болно. Ямар ч тохиолдолд засаг захиргаанаас нүүлгэн шилжүүлэлтээс өөр арга судалж, өртөж буй хүмүүст боломжтой аргыг санал бодлоо илэрхийлэх бололцоог олгох ёстой /олон талт зөвшилцөл хийх шаардлагыг доороос харна уу/.

Нүүлгэн шилжүүлэлт болзошгүй ямар нэгэн төслийг боловсруулахдаа төслийг удирдаж буй хүмүүс тухайн газар дээр, эсвэл ойр орчимд нь амьдарч буй хүмүүсийн амьжиргаанд хэрхэн нөлөөлөх талаар бүх судалгааг хийсэн эсэхэд засаг захиргаанаас анхаарах ёстой. Хэрвээ тохиромжтой хэд хэдэн байршлын сонголт байвал нүүлгэн шилжүүлэлт шаардлагагүй, эсвэл цөөн хүнийг нүүлгэх шаардлагатай хувилбарыг сонгох нь зүйтэй.

Тухайн төслийн хувьд боломжтой бүх байршлыг судалсан, хүмүүсийн амьжиргаанд нөлөөлөх хүчин зүйлийг анхаарч, нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийн, эсвэл аль болох цөөн хүн хамрах шийдвэр гаргасан гэдгээ засаг захиргааны зүгээс бүрэн нотолж чадах ёстой.

Нүүлгэн шилжүүлэлтийн тухай НҮБ-ын журамд “Төр нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх бүх боломжийг бүрэн судалж үзэх ёстой. Энэ үйл явцад өртөж болзошгүй хүн амын бүлгүүд, хувь хүмүүс, үүнд эмэгтэйчүүд, уугуул иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, мөн өртөж болзошгүй иргэдийн эрх ашгийг төлөөлж буй хүмүүсийн аль аль нь хэрэгцээтэй мэдээлэл авах, энэ бүх үйл явцын туршид зөвлөлдөх, оролцох, боломжтой бусад хувилбаруудыг санал болгох бүрэн эрхтэй бөгөөд гаргасан саналыг нь засаг захиргааны зүгээс анхааралдаа авах ёстой” гэж заажээ.

## ҮР БҮТЭЭЛТЭЙ ЗӨВШИЛЦӨХ НЬ

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн асуудал эрхэлсэн НҮБ-ын хороо нь нүүлгэн шилжүүлэлтэнд өртөж буй хүмүүстэй “үр бүтээлтэй зөвшилцөх” аргыг албадан нүүлгэн шилжүүлэлтээс хамгаалах үндсэн арга” гэж үзжээ. Хороо “Гишүүн орнууд ямар нэгэн нүүлгэн шилжүүлэлт хийхээс өмнө, ялангуяа олон тооны хүнийг хамруулсан нүүлгэн шилжүүлэлтийн өмнө, өртөж буй хүмүүстэй зөвшилцөж, нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх, эсвэл хийхгүйн төлөө бүх боломжтой хувилбаруудыг судалж үзсэн гэдгээ баталгаажуулах ёстой” гэж заасан байдаг.

Энэ нь хэд хэдэн шалтгааны улмаас их чухал. Нүүлгэн шилжүүлэлтэнд өртөж буй хүмүүс, сонирхогч талуудын хэрэгцээг хангасан боломжит хувилбарыг тодорхойлсноор нүүлгэн шилжүүлэлтийн цар хүрээг багасгах, эсвэл бүр зогсоож болгож болно. Зөвшилцөлд хүрснээр нүүлгэн шилжүүлэлтийн үед хүч хэрэглэх явдлыг багасгах, эсвэл бүр хүч хэрэглэхгүй нөхцлийг бүрдүүлж болох бөгөөд нүүлгэн шилжүүлэлтэнд өртсөн хүмүүс шинэ газар суурьшигдаа хэрэгцээг нь бүрэн хангасан нөхцөлд л очиж болно.

Хэдийгээр зөвшилцөх үйл явц нь ажлыг удаашруулж байгаа, зардал мөнгө их шаардсан мэт боловч, эцсийн бүлэгт тухайн төслийн зардлыг хэмнэх /ялангуяа нүүлгэн шилжүүлэлтээс болж ажлын байр, хоол унд, сургууль эмнэлгийн үйлчилгээнээс холдох гэх мэт нийгмийн асуудлуудыг шийдвэрлэсэн тохиолдолд/, тэгш бус байдал, нийгмийн хямрал, салан тусгаарлал гэх мэт сөрөг нөлөөг багасгахад чухал нөлөөтэй.

## ДЭЛГЭРЭНГҮЙ, ЗӨВ МЭДЭЭЛЛИЙГ ЦАГ ТУХАЙД НЬ ТҮГЭЭХ

Ямарваа нэгэн зөвшилцөлд нүүлгэн шилжүүлэлтэнд өртөж буй хүмүүсийг оролцуулахын тулд цаг тухайд нь дэлгэрэнгүй, зөв мэдээлэлээр хангах нь түгээх нь чухал юм. Зөвшилцөл эхлэхээс өмнө нүүлгэн шилжүүлэлтэнд өртөх магадлалтай хүмүүс дараах мэдээллийг өгөх шаардлагатай. Үүнд:

- Нүүлгэн шилжүүлэлтийн учир шалтгаан бусад хийх гэж байгаа, нүүлгэн шилжүүлэлт хийсний дараа тухайн газар, эсвэл өмчийг ямар зориулалтаар ашиглах
- Нөлөөлөлд өртсөн хүмүүст олгох нөхөн олговор, шинэ орон байрны талаарх мэдээлэл, мөн ямар тохиолдолд энэ нь үйлчлэхгүй байх талаархи тайлбар
- Засаг захиргаанаас нүүлгэхээс зайлсхийх өөр ямар аргуудыг судалж үзсэн талаар
- Нүүлгэн шилжүүлэлт, шинэ газарт суурьшилт хэрхэн явагдах, энэ үйл явцад оролцож буй төрийн болон гуравдагч этгээдийн үүрэг оролцоог тайлбарлах
- Засаг захиргаа болон нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой шийдвэр, үйл явцын талаар санал гомдлоо илэрхийлэх боломжууд
- Зөвшилцөх үйл явцын зорилго, аргачлал, хугацааны талаар мэдээлж, нүүлгэн шилжүүлэлтэнд өртөж буй хүмүүсийн саналаа илэрхийлэх боломжуудыг дурьдана

4

UIN.MN  
СҮЛДЭГ АНЫ САН

Эдгээр мэдээлэл нь тухайн орон нутгийн удирдлага төдийгүй бүх хүнд хүрч байгаад хяналт тавина. Мэдээллийг бичгээр хүргэх ба орон нутгийн хэлээр, эсвэл тухайн бүлэг хүмүүсийн ойлгодог хэлээр бичигдсэн байх ёстой. Тухайн газар нутгийн бүх хүмүүс, ялангуяа бичиг үсэг мэддэггүй хүмүүс зөвшилцөлд оролцох боломжоор хангагдсан байх ёстой. Жишээ нь, хэрэгцээтэй үед мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл телевиз, радиогоор явуулж, олон нийт, фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулж болно.

Өмнө нь дурдсанчлан, нүүлгэн шилжүүлэлтэд үйл явцад оролцоход бэрхшээлтэй байж болзошгүй хүн амын бүлгүүдэд мэдээлэл хүргэхийн тулд засаг захиргааны зүгээс нэмэлт арга хэмжээнд авч явуулах шаардлагатай.

## ХОХИРОГЧ ТАЛУУДАЙ УУЛЗАЖ ЯРИЛЦАХ

Санал болгож буй нүүлгэн шилжүүлэлтэнд өртөж буй бүх хүнд нүүлгэн шилжүүлэлт болон түүнтэй холбоотой төлөвлөгөө, нөхөн олговор гэх мэт асуудлаар бодож тунгаах, ярилцаж зөвшилцөх, санал бодлоо илэрхийлэх хангалттай хугацаа боломж олгох хэрэгтэй. Хохирогч тал нь өөрсдийн санал бодлыг дундаасаа сонгосон төлөөлөгчөөр дамжуулж, эсвэл жижиг бүлгээр, хувиараа илэрхийлж болно. Тэд бас нүүлгэн шилжүүлэлтээс өөр арга замыг санал болгож болно. Хувь хүмүүс эсвэл хэсэг бүлэг хүмүүст мэдээлэл хайх, олж авсан мэдээлэлдээ үндэслэн асуудал дэвшүүлэх, хариулт авах бүх бололцоог засаг захиргаанаас бүрдүүлэх өгөх хэрэгтэй. Түүнчлэн засаг захиргааны зүгээс мэдээлэл түгээх хурал, уулзалтуудыг зохиож, оролцогчдод асуулт тавих, нүүлгэн шилжүүлэлтээс өөр арга замыг санал болгох, урьдчилан гаргасан шийдвэрүүдийг няцаах боломж олгох ёстой. Хохирогч талуудтай хамтарч ажиллаж буй байгууллагууд, өмгөөлөгчид тухайн хуралд оролцох ёстой бөгөөд ийм хурлын тов, протокол зэргийг сайн мэдээлж, түгээх хэрэгтэй. Хүмүүс хурлын протоколыг унших, буруу зөрүү бичигдсэн зүйлийг засаж залруулах боломжтой байх ёстой.

Хүмүүсийн эрхийг зөрчиж болзошгүй техникийн үндэслэлтэй төслүүдийн хувьд /тухайлбал, хүмүүсийн гэр орон байгаа газарт, эсвэл шинээр суурьших газартай ойрхон агаар бохирдуулагч бодис ялгаруулдаг томоохон үйлдвэр барьж байгуулах гэсэн тохиолдолд/, болзошгүй үр нөлөө, хэрхэн бууруулах тухай мэдээллийг хүмүүст ойлгомжтой хэлбэрээр тайлбарлаж ойлгуулах шаардлагатай.

Түүнчлэн, засаг захиргааны зүгээс хараат бус мэргэжлийн, хууль эрх зүй, бусад үйлчилгээг хүмүүст хүргэж болно. Ингэснээр хүмүүс өөрсдийхөө эрхийг ойлгож, боломжуудаа мэдэж, үйл явцыг хянах чадвартай болно. Нэлээн олон тооны хүн нүүлгэн шилжүүлэлтэнд өртөх гэж буй тохиолдолд засаг захиргааны зүгээс олон нийтийн төлөөлөгчийн туслалцааг авах сонирхолтой байдаг. Тухайн төлөөлөгч нь хүмүүс дотроос сонгогдож, төлөөлөх бүрэн эрхтэй, буцаж мэдээллэх үедээ нийт хүмүүсийг хамруулж чадаж, гарсан ямар нэгэн саналд олонтой зөвшилцсөний эцэст хариу өгч байгаа эсэхийг баталжуулах хэрэгтэй. Хэдийгээр төлөөлөгч томилсон ч, засаг захиргааны зүгээс мэдээлэл, зөвшилцдөгөөрөө зөвшилцөж, нийтийн хурал, уулзалт зохион байгуулж, хүмүүст чөлөөт байдлаар мэдээлэл авах эрхийг нь хангаж өгөх шаардлагатай.

Нийгмийн доторх ялгаварлан гадуурхалт, эсвэл сонирхолын зөрчлөөс улбаатай / жишээ нь, байр хөлслөгч, байрны эзний маргаан гэх мэт/ үйл явцад оролцоход хамгийн их бэрхшээлтэй тулгарч болзошгүй бүлэг хүмүүстэй тусад нь уулзах шаардлага байнга тулгардаг. Ямар ч тохиолдолд засаг захиргааны зүгээс эрх ашиг нь хамгийн их зөрчигдөх бүлгүүдийг хамгаалах ёстой бөгөөд аливаа нэгэн ялгаварлан гадуурхал гаргахгүй байхад анхаарах ёстой. Шинээр суурьших шийдэл хүн бүрд нийцэхгүй байж болзошгүй тул өөр өөр хэрэгцээг хангах үүднээс нөхөн олговор болон шилжин суурьшилтын өөр хувилбарыг бодож олох хэрэгтэй байж болно. Жишээ нь, байр эзэмшигчид нөхөн олговор аваад санаа амарч болох ч, байр түрээслэгчдийн хувьд өөр орон байр олоход туслалцаа хэрэгтэй байж ч магад. Хэрвээ тэд орон байр олсон ч төлбөрийг төлж дийлэхгүйд, орлого багатай хүн амын бүлэгт зориулж байрны түрээсийн татаас, тусгай байраар хангах шаардлага гарч болзошгүй. Тийм учраас, зөвшилцлийн үед хамгийн эмзэг бүлгийн хүмүүстэй уулзаж зөвшилцөх нь чухал юм. Ингэснээр тэд эрх тэгш зарчмаар өрнөж буй үйл явцад оролцох, хэрэгцээ нь тодорхойлж, шийдвэрлэх арга замаа судалж тогтооход ач холбогдолтой.

4

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

## ХОХИРОГЧ ТАЛУУДЫН ДЭВШҮҮЛСЭН БУСАД ГАРЦЫГ СУДАЛ

Нүүлгэн шилжүүлэлт хийх шийдвэрийг гаргахаасаа өмнө засаг захиргааны зүгээс хохирогч талуудын санал болгосон бусад арга, гарцуудыг судалж үзэх хэрэгтэй.

Нүүлгэн шилжүүлэлтээс бусад арга замыг судалж үзэхэд орон нутгийн засаг захиргаа голлох үүрэгтэй. Орон нутгийн хүн амтай зөвшилцсөний үндсэн дээр суурин газрын зохион байгуулалтыг бага зэрэг өөрчлөн, хүн амын нягтшил ихтэй орон сууцны хороолол барих шийдвэр гаргах нь нүүлгэн шилжүүлэлтээс татгалзах нэг арга байж болох юм. Газар эзэмшлийн маргаан, эсвэл тухайн газар эзэмшигчийн өмчлөх эрхийг сэргээх гэх мэтээс үүдэн шилжүүлэлт явагдах тохиолдолд сонирхогч талуудын дунд зуучилж, газар хамтран эзэмших гэх мэт өөр арга замыг орон нутгийн засаг захиргаанаас тодорхойлж болох юм.

Нүүлгэн шийлжүүлэх эцсийн шийдвэр нь яагаад хийх болов, ямар өөр арга, гарцуудыг судалж үзсэн, яагаад тэдгээр нь амжилтанд хүрээгүй, нүүлгэн шилжүүлэлтээс урьдчилан сэргийлэх, үр нөлөөг нь багасгахад ямар арга хэмжээ авсан талаарх бүх мэдээллийг агуулсан байх ёстой. Түүнчлэн хохирогч талуудын санал шүүмж шинээр суурьших, нөхөн олговор олгох төлөвлөгөө, нүүлгэн шилжүүлэлтийн цаг хугацаа, үйл явцад хэрхэн туссан талаар мэдээлэл байх шаардлагатай.

НҮБ-аас гаргасан нүүлгэн шилжүүлэлтийн гарын авлагад “Нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой шийдвэрийг өртөгдөж буй бүх хүнд орон нутгийн хэлээр тодорхой хугацааны өмнө мэдэгдэх ёстой. Нүүлгэн шилжүүлэлтийн товд уг шийдвэрийг гаргасан бүх үндэслэл багтах ёстой. Үүнд:

А. Үүнээс өөр арга зам байгаагүйн тайлбар

Б. Ямар арга замуудыг судалсан тухай бүх нарийн мэдээлэл,

В. Өөр арга замгүй тохиолдолд, нүүлгэн шилжүүлэлтийн үр дагавраас урьдчилан сэргийлэх, багасгах арга замуудыг тусгасан байх ёстой” гэжээ.

“Эцсийн шийдвэр бүрийг засаг захиргааны төдийгүй шүүхийн хяналтанд оруулах боломжтой”.

4

УИХ.МН  
СУДАЛГААНЫ САН

## УУГУУЛ ИРГЭД БА ЧӨЛӨӨТ, МЭДЭЭЛЭЛТЭЙ УРЬДЧИЛСАН СОНГОЛТ

Уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ын тунхаглал нь уугуул иргэдийн “өөрсдийн зан заншилаа”-ын дагуу эзэмшиж, амьдарч, ашиглаж байсан газар, нутаг, баялгийг хүртэх эрхтэй” гэдгийг бататгасан бөгөөд төрөөс хуулиар хамгаалж, хүндэтгэх ёстойг заажээ. Уугуул иргэд уламжлалаараа эзэмшиж амьдарч ирсэн газар нутгийг ашиглах, эсвэл газар нутгаас нүүлгэх төлөвлөгөөг зөвхөн тэдний зөвшөөрлийн дагуу явуулах ёстойг Тунхаглалд баталгаажуулсан байна.

Тунхаглалын 10 дугаар зүйлд “Уугуул иргэдийг газар нутгаас нь албадан хөөж болохгүй. Тухайн уугуул иргэдийг чөлөөт, мэдээлэлтэй, урьдчилсан сонголтгүйгээр, нөхөн олговор олгох шударга зөвшилцөөнгүйгээр, боломжтой бол эргэж ирэх нөхцөл олгоогүй тохиолдолд т нүүлгэн шилжүүлэх ёсгүй” гэж заажээ. Уугуул иргэдийн чөлөөт, урьдчилсан, мэдээлэлтэй сонголтыг Арьс өнгөөр ялгаварлан гадуурхалтыг устгах НҮБ-ын хороо, НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо, НҮБ-ын Хүний эрхийн хороо, Хүний эрхийн Америк дундын Шүүхээр баталгаажуулсан юм.

Хэрэв засаг захиргаанаас уугуул иргэдийн уламжлалт газар нутагтай холбоотой, нүүлгэн шилжүүлэх төсөл хэрэгжүүлэх бол, урьдчилан тэдгээр хүмүүсээс зөвшөөрөл авах хэрэгтэй.

4

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## ҮР НӨЛӨӨЛЛИЙГ ҮНЭЛЭХ НЬ

Нүүлгэн шилжүүлэлтийн тухай НҮБ-ын журамд “Нүүлгэн шилжүүлэлтийг аль болох багасгах арга замуудыг хайж олоход төрөөс анхаарах шаардлагатай. Хөгжилд чиглэсэн нүүлгэн шилжүүлэлт шаардлагатай аливаа төслийг хэрэгжүүлэхээсээ өмнө, бүх салбарыг хамарсан үр нөлөөллийн үнэлгээг хийж, өртөж болзошгүй хувь хүмүүс, нийгмийн бүлгүүдийн албадан нүүлгэн шилжүүлэлтээс хамгаалагдах эрх зэрэг бүх л эрхийг нь хангах арга замуудыг шийдвэрлэх ёстой. “Нүүлгэн шилжүүлэлтийн үр нөлөө”-ний үнэлгээ нь байж болох гарц вэ, гарц болзошгүй хор хохирлыг бууруулах арга хэмжээг тусгасан байх хэрэгтэй” гэж заажээ.

Тухайн газар нутгийн хүн ардад нүүлгэн шилжүүлэлтийн үр нөлөө харилцан адилгүй тусч болзошгүй. Нөлөөлөл олон хүчин зүйлээс хамааран адилгүй илэрдэг. Тухайлбал, хүмүүсийн эдийн засаг, нийгмийн байдал, арьсны өнгө, үндэсний цөөнх, иргэний харьяалал, хүйс, шашин шүтлэг, нас, хөгжлийн бэрхшээл зэрэг олон асуудал хөндөгдөнө. Орон нутгийн захиргаа энэхүү хор хохирлыг бууруулахад чухал нөлөө үзүүлэх боломжтой байж чадах бөгөөд хүний эрхийг хамгаалж чадна. Хор нөлөөллийг бууруулах чухал арга нь нөлөөллийн үнэлгээг нарийвчилсан байдлаар хийх бөгөөд нүүлгэн шилжүүлэлт, шинээр суурьших үйл явцын талаар чухал шийдвэр гаргахад туслана.

Энэхүү үнэлгээг хийхэд бүх оролцогч талуудын, ялангуяа нүүлгэн шилжүүлэлтэнд өртөж буй хүмүүсийн идэвхтэй оролцоо маш чухал.

Идэвхтэй оролцоог хангахын тулд өртөж байгаа хүмүүст үнэлгээний хийх аргачлал, зорилгыг сайн ойлгуулах хэрэгтэй. Мэдээллийг тухайн орон нутгийн хэлээр бэлтгэх хэрэгтэй бөгөөд бичиг үсэг тайлагдаагүй хүн ч ойлгож болохуйц хүртээмжтэй байх ёстой.

Үнэлгээ нь тухайн орон нутгийн суурь мэдээллийг агуулахаас байхаас гадна, дараах мэдээллийг нэмж өгөх ёстой. Үүнд:

- Нүүлгэн шилжүүлэлт хийх газар
- Суурьшил, түүнтэй холбоотой хууль эрх зүйн асуудлууд

ОИХ.МН  
СҮДАЛГААНЫ САН

- Тухайн газарт амьдарч буй өрх, хүмүүсийн тоо /энэ тоонд орон гэргүй гэгдэх хүмүүс багтах байх ёстой/. Энэ тоог цаашлаад хүйсийн гэх мэт ялгаварлан гадуурхал гарж болзошгүй хүчин зүйлээр ангилсан байх ёстой.
- Тухайн хүмүүс тус газарт хэдэн жил, эсвэл сараар амьдарч буй талаарх мэдээлэл
- Тухайн газарт амьдардаггүй ч, ажил эрхэлдэг, эсвэл тухайн газраар дамжин бусад газар амьдралын эх үүсвэрүүдэд хүрдэг хэдэн хүн байгаа талаарх мэдээлэл
- Тухайн газарт амьдарч буй хүмүүсийн байдлын мэдээлэл /газар эзэмшигчид, түрээслүүлэгч, түрээслэгч, албан бусаар амьдарч буй хүмүүс, түүнчлэн орон гэргүй гэж тооцогдож буй хүмүүсийн тоо/
- Нүүлгэн шилжүүлэлтэнд өртөж буй хүмүүсийн эрхэлж буй ажил, орлогын эх сурвалжууд /үүнд гэрээрийн хөдөлмөр орно/
- Тухайн газрын нийгмийн үйлчилгээний газрууд /сургууль, эмнэлэг, усан хангамж, ариун цэврийн байгууламж, хог хаягдлын цэг, гэрэлтүүлэг зэрэг/
- Тухайн газар нутагт голчлон ашигладаг барилгын материал
- Дэлгүүр, хоол, үйлчилгээний газрууд

Суурь мэдээллийг цуглуулсаны дараагаар, нөлөөллийн үнэлгээг хийх шаардлагатай. Тухайн үнэлгээ нь нүүлгэн шилжүүлснээр хийснээр орон нутгийн хүмүүст нийтэд нь учрах нөлөөллийг тооцохоос гадна тухайлсан бүлэг хүмүүст нийгмийн болон бусад нөхцөлөөс шалтгаалж нүүлгэн шилжүүлэлт хэрхэн тусахыг тогтоох аргачлалаар хийгдсэн байх ёстой.

Нөлөөллийн үнэлгээнд дараах тусгайлсан мэдээлэл орсон байх ёстой.  
Үүнд:

- Шинэ орон байраар хангагдах боломж,
- Нийтийн тээвэр, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, бусад нийгмийн үйлчилгээг хүртэх боломж,
- Ажил эрхлэлт, бусад орлогын эх үүсвэрийн боломж,
- Нийгмийн болон орон нутгийн танил тал, найз нөхдийн хүрээ
- Нийгмийн амьдралд оролцох боломж

Орон нутгийн захиргаа нөлөөллийн үнэлгээний дүнг өртөж буй хүмүүс, тэдний төлөөлөгчдөд танилцуулж, мэдээллийг нарийвчлах үүднээс санал шүүмжийг нь хүлээн авах хэрэгтэй. Тухайн орон нутгийн бүх хүнд хүртээмжтэй хэлбэрээр үнэлгээний тайланг боловсруулж түгээх шаардлагатай.

Нөлөөлөлд өртөж буй хүмүүс, тэдний төлөөлөгчдөөс гаргасан санал шүүмжийг бүрэн судалж дууссаны дараа үнэлгээг дууссанд тооцож болно. Судалсан гэдгээ харуулах нотолгоог орон нутгийн захиргаа бэлтгэж хадгалсан байх ёстой.

Нөлөөллийн үнэлгээг нүүлгэн шилжүүлэх боломжтой эсэх шийдвэрийг гаргахад ашиглах хэрэгтэй. Нүүлгэн шилжүүлэхээс өөр аргагүй тохиолдолд нөлөөллийн үнэлгээний үр дүнг нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор, шинээр суурьших бүхий л үйл явцад ашиглах ёстой.

Боломжтой бол сөрөг нөлөөг бууруулахтай холбоотой зардлыг нүүлгэн шилжүүлэлтийн төслийн нийт төсөвт суулгаж өгөх хэрэгтэй.

УИХ.МН  
СУДАЛГААНЫ САН

# НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙГ ХАНГАЛТТАЙ ХУГАЦААНЫ ӨМНӨ МЭДЭЭЛЭХ НЬ

Зөвшилцөл дууссаны дараа орон нутгийн захиргаанаас нүүлгэн шилжүүлэлтийн зарыг нөлөөлөлд өртөх хүмүүст хангалттай урт хугацааны өмнө түгээх хэрэгтэй. Зарыг бичгээр хүргүүлэх ба, тухайн орон нутгийн хэлээр зарыг хүргэх тэгэх боломжгүй тохиолдолд орчуулгын үйлчилгээ зохион байгуулах хэрэгтэй. Бичгэн зарыг түгээхээс гадна бичиг үсэг тайлагдаагүй хүмүүст ойлгогдох бусад аргаар зарыг түгээнэ. /радио, телевизээр зар өгөх, жижиг бүлгийн болон нийтийн хурал уулзалт зохион байгуулах гэх мэт/.

Зар, нүүлгэн шилжүүлэлт эхлэх өдрийн хооронд хангалттай хугацааг тогтоож өгөх хэрэгтэй бөгөөд энэ хугацаанд хүмүүст хуулийн хүрээнд нүүлгэх шийдвэрийг зогсоох арга хэмжээг авч болно. Түүнчлэн хангалттай цаг хугацаа өгснөөр хүмүүст болзошгүй хохирлоо тооцож, нөхөн олговор авах шийдвэр гаргахад туслана. Мөн шинээр суурьших газрын талаарх зөвшилцлийг дуусгах, тухайн газрыг бэлтгэхэд хувь нэмрээ оруулна.

Нүүлгэн шилжүүлэлтийн тухайн НҮБ-ын журамд “Хэрэв нийгмийн бүх хүрээнд хангалттай ярилцсаны дараагаар нүүлгэн шилжүүлэлт хийх шаардлагатай гэсэн шийдвэр гарвал, нүүлгэлт эхлэхээд дор хаяж 90 хоногийн өмнө, тухайн газар орны хүмүүст мэдэгдэх шаардлагатай” гэж заажээ. Олон хүнийг хамарсан нүүлгэн шилжүүлэлтийн үед 90 хоног нь хамгийн бага хугацааг илэрхийлнэ гэсэн үг юм.

Нүүлгэн шилжүүлэлтийн зард нүүлгэн шилжүүлэлт эхлэх өдөр сарыг тодорхой зааж бүх алхмыг тайлбарласан байх ёстой. Түүнчлэн нөхөн олговрын үндэслэл, нөхцлүүд, шинээр суурших арга хэмжээг тодорхойлсон байхаас гадна, шүүх, захиргааны байгууллагад, гомдол гаргах, шийдвэрийг цуцлах зарга үүсгэх боломжуудыг зааж өгөх ёстой.

Нүүлгэн шилжүүлэх зар өгсөн ч, тухайн хугацаанд нийгмийн бүхий л үйлчилгээгээ авсан хэвээрээ байх бөгөөд үүнд усан хангамж, эрүүл ахуй, цахилгаанаар хэвийн хангахыг байгаа орон нутгийн захиргаа анхаарах шаардлагатай.

4

## ХУУЛЬ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ НЬ

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн асуудал эрхэлсэн НҮБ-ын хорооноос “Албадан нүүлгэлтийн эсрэг хамгаалах хамгийн чухал аргын нэг нь нүүлгэн шилжүүлэх зар авсан хүмүүст хууль зүйн тусламж, үйлчилгээг үзүүлэх явдал мөн”. Түүнчлэн төрөөс хууль зүйн үйлчилгээ туслалцаа хэрэгтэй хүмүүст тусламж үйлчилгээч үзүүлэх хэрэгтэй гэж заасан байдаг.

НҮБ-ын хороо орон байртай байх эрхийг зөрчихөөс байдлаас хамгаалах арга хэмжээг хуулийн тогтолцоондоо суулгах хэрэгтэй гэж зөвлөн “Шүүхийн шийдвэрээр нүүлгэн шилжүүлэлтийг төлөвлөх явдлаас урьдчилан сэргийлэх хууль эрх зүйн арга хэмжээг тусгах хэрэгтэй гэж заажээ.

Нүүлгэн шилжүүлэлтийн тухайн НҮБ-ын журамд нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой бүх шийдвэрийг “Засаг захиргааны болон шүүхээр эргэн хянах боломжтой” гэж тэмдэглэсэн байна. Үүнд нэрвэгдсэн хүмүүс хууль эрх зүйн зөвлөгөөг шаардлагатай үед үнэ төлбөргүй авна гэдгийг бас дурдсан байна.

Тийм учраас орон нутгийн захиргаа нүүлгэн шилжүүлэлтэнд өртөх хүмүүст шийдвэрийг зогсоох, шүүхэд гомдол мэдүүлэх боломж олгох хэрэгтэй. Өртөж буй хүмүүс хууль эрх зүйн хамгаалалтыг байгаа, хэрхэн хүртэж, тусламж үйлчилгээ авах талаар мэдээлэлтэй байх ёстой. Ийм мэдээллийг нүүлгэн шилжүүлэлтийн шат бүхэнд өгч болох ч, нүүлгэн шилжүүлэлтийг цуцлах шийдвэр гаргуулах бол мэдээллийг нүүлгэн шилжүүлэлтийн зарыг түгээх үедээ хамтад нь өгөх хэрэгтэй.

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

4

# ОРОН БАЙРААР ХАНГАХ БА НӨХӨН ОЛГОВОР

«Нүүлгэн шилжүүлэлт хийснээр иргэд орон гэргүйдэх, эсвэл бусад эрхд нь зөрчигдөж болзошгүй эрсдэлтэй байдалд орох ёсгүй. Нүүлгэн шилжүүлэлтэнд өртсөн хүмүүс өөрийнхөө төлөө тэмцэх боломжгүй тохиолдолд төрөөс нөөц бололцооныхоо хүрээнд тэдгээр хүмүүсийг орон байраар хангах, шинээр суурьших газар олгох, эсвэл сэтгэл ханамжтай газарт шилжүүлэх гэх мэт бүхий л зохистой арга хэмжээ авах ёстой.»

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн асуудал эрхэлсэн НҮБ-ын хороо, Ерөнхий Зөвлөмж № 7: Шаардлага хангасан орон байртай байх эрх: албадан нүүлгэлт, 1997 оны 5 сарын 20, 16 дугаар мөр

## БҮХ АЛДАГДАЛД НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ НЬ

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн асуудал эрхэлсэн НҮБ-ын хорооноос “Гишүүн орнууд нүүлгэн шилжүүлэлтийн улмаас алдсан хувийн болон үл хөдлөх бүх хөрөнгийн алдагдлын төлөө хүмүүс нөхөн олговор авах ёстойг онцгойлон анхаарах хэрэгтэй” гэж тэмдэглэжээ.

Орон нутгийн захиргаа хүмүүст болзошгүй бүх алдагдал, хохирлыг тооцох цаг хугацаа олгон нөхөн төлбөрийг барагдуулна. Өөрөө орон гэр олж чадахгүй хүмүүст мөнгөн олговроос олгохоос илүүтэйгээр амьдарч болохуйц гэр орон олгох нь зүйтэй байдаг.

5

ОИН.МН  
СУДАЛГААНЫ САН

Нүүлгэн шилжүүлэлтийн тухай НҮБ-ын журамд “Нүүлгэн шилжүүлэлт зайлшгүй шаардлагатай, тэрхүү шаардлага нь нийтийн эрх ашигт нийцэж байгаа тохиолдолд, төрөөс хувийн үл хөдлөх /үүнд хөрөнгийн хүү болон эзэмшлийн эрх бас хамаарна/ болон бусад хөрөнгө, эдийн алдагдлыг нөхөх шударга, тэнцвэртэй олговор олгох, эсвэл баталгаажуулах ёстой. Эдийн засгийн хувьд үнэлж болохуйц бүхий л хохиролд тухайн хохирлын хэмжээ, нөхцөл байдлыг харгалзан нөхөн олговор олгох ба үүнд: амь насаа, эсвэл эд эрхтнээ алдах, бие сэтгэл зүйн хохирол, ажил эрхэлт, боловсрол, нийгмийн халамжид гарсан алданги, эд материалын гэмтэл, цалин хөлсний алдагдал, сэтгэл санааны дарамт, хуулийн зөвлөгөө, үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээний зардал, сэтгэл зүйн болон нийгмийн үйлчилгээ гэх мэт орно. Ямар ч нөхцөлд бэлэн мөнгөний нөхөн олговор нь шинээр газар олгох, хөрөнгийн эх үүсвэр гэх мэт бодит нөхөн олговрыг орлохгүй. Газар чөлөөлөхийн тулд нүүлгэн шилжүүлэлт хийж байгаа тохиолдолд тухайн газартай тэнцэхүйц хэмжээний чанар, үнийн хувьд ойролцоо, эсвэл дээгүүр газрыг нөхөж олгох хэрэгтэй” гэж тэмдэглэжээ.

Өртөж буй хүн ам бэлэн мөнгөөр нөхөн олговроо авах сонирхол илэрхийлвэл, орон нутгийн захиргаанаас тэдгээр хүмүүст мэдлэгтэй сонголт хийх боломж олгох үүднээс шинэ орон байрны хувилбарууд, нөхөн олговрын тухай мэдээллийг ялгаагүй өгөх ёстой. Түүнчлэн тухайн өрх гэрийн гишүүн бүр ялангуяа эмэгтэйчүүд бэлэн мөнгө авах хүсэлтэй эсэхийг баталгаажуулах ёстой. Тухайн өрхийн эрэгтэй, эмэгтэй хүмүүс ялгаагүй тэрхүү бэлэн мөнгийг тэгш зарах эрхтэй байх. Ганц бие, эсвэл өрх толгойлсон эмэгтэйчүүдэд бэлэн мөнгийг эмэгтэйд өөрт нь өгөх ёстой.

Бэлэн мөнгө авах сонирхолтой хүмүүст орон байр судлах, шинэ орон байр авахад мөнгө нь хүрэлцэхүйц хэмжээтэй байгаа эсэхэд дүгнэлт хийх хангалттай их хугацааг олгож, үүндээ үндэслэн эцсийн шийдвэр гаргах боломж олгоно.

СИ.МН  
СУДАЛГААНЫ САН

# ӨӨРӨӨ ОРОН БАЙР ОЛЖ ЧАДАХГҮЙ ХҮМҮҮСТ БОЛОМЖИЙН ОРОН БАЙР ОЛГОХ НЬ

Өөрөө бие дааж орон байр олох чадавхгүй хүмүүст боломжийн орон байр олж өгөхөд орон нутгийн захиргаа анхаарах ёстой бөгөөд нүүлгэн шилжүүлэлтээс болж хэн ч орон гэргүйдэх, эсвэл бусад эрхд нь зөрчигдөхийц эрсдэлд орох ёсгүй.

## ХЭН ОРОН БАЙР, ШИНЭ СУУРЬШИЛТАНД ХАМРАГДАХ ЭРХТЭЙ ВЭ?

Орон байраар хангах гол шалгуур нь тухайн хүний амьдарлын нөхцөл, өөрөө орон байраа олох чадвартай эсэхээс хамаарна. Нүүлгэн шилжүүлэлтийн үр дүнд орон гэргүй хоцрох, эсвэл өөрийнх олж чадах орон байр нь шаардлагад нийцэхгүй, баталгаагүй байж мэдэх хүмүүст боломжийн орон байраар хангах асуудлыг орон нутгийн захиргаа шийдэх ёстой. Нүүлгэн шилжүүлэлтэнд өртсөн хүмүүсийг эзэмшлийн баталгаа, бүртгэл, эсвэл шилжин ирэгч гэх мэтээс шалтгаалан ялгаварлаж болохгүй. Хүмүүсийг хууль тогтоомж мөрдөөгүйн төлөө шийтгэх гэсэн мэт орон байртай байх эрхийг нь зөрчиж болохгүй бөгөөд ямар ч тохиолдолд зохих журмын дагуу асуудлыг шийдвэрлэх ёстой. Тийм учраас жишээ нь хил гаалийн дүрэм журмыг зөрчсөнийх нь төлөө хүмүүсийг хил нэвтрүүлэхгүй байж болох “хууль бус” цагаач гэсэн утгаар орон гэрийг нь нураан, устгаж болохгүй гэсэн үг юм.

5

ОИН.МН  
СУДАЛГААНЫ САН

# ШИНЭ ОРОН БАЙР, ШИЛЖИН СУУРЬШИХ ГАЗАР ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫГ ХАНГАЖ БҮЙ ЭСЭХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ НЬ

Олон хүнийг суурьшуулан, шинээр орон байраар хангах тохиолдолд Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн асуудал эрхэлсэн НҮБ-ын хорооны болон бусад олон улсын хүний эрхийн стандартуудад тодорхойлсноор тэрхүү орон байр нь “шаардлага хангасан” гэж тооцогдох шалгуурыг давах ёстой. Үүнд ялгаварлан гадуурхалыг хорьсон байдаг. Тийм учраас, орон нутгийн захиргаа нь дараах нөхцлийг баталгаажуулах ёстой. Үүнд:

- ❑ Хүмүүс өөрийн шинэ байрандаа эзэмшлийн баталгаатай байх ёстой. Үүнд түрээсийн гэрээ, тухайн газарт амьдрах эрхийг баталгаажуулсан баримт бичиг, тухайн иргэний өмчлөгчийн эрхийг баталгаажуулсан эрхийн үнэмлэх зэргийг өгнө. Ямар ч тохиолдолд, хүмүүс албадан нүүлгэлтээс хамгаалагдсан байх ёстой.
- ❑ Эзэмшлийн баталгаа нь өрхийн эрэгтэй эмэгтэй хүмүүст адил тэгш хамгаалалт өгөх ёстой учраас аливаа баталгаа нь хамтын нэр дээр байх ёстой. Ганц бие, эсвэл өрх толгойлсон эмэгтэйчүүдийн хувьд түрээсийн гэрээ, эсвэл өмчийн гэрчилгээ гэх мэт нь тухайн эмэгтэйн нэр дээр байх ёстой.
- ❑ Орон байр нь хоол хийх, дулаацах, цэвэр бохир устай, цахилгаан хангамжтай, хог хаягдлыг гадагшлуулах суваг, гудамж талбайн гэрэлтүүлгээр хангагдсан байх ёстой.
- ❑ Ашигласан барилгын материал нь аюулгүй, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх ёстой.
- ❑ Орон байр нь агааржуулалтын сүлжээтэй байж, байгалийн үзэгдлүүд салхи шуурга, хүйтрэл зэргээс хамгаалах ёстой. Байшин болгон тухайн улсын хууль дүрмийн дагуу баригдсан байх ёстой.
- ❑ Нүүлгэн шилжүүлэлтэнд өртсөн хүмүүс тухайн орон байрын төлбөр тооцоог төлж чадахуйц байна. Жишээ нь: шинэ байрыг түрээслэх тохиолдолд хүмүүс хоол унд, хувцас хунар гэх мэт өөрийн бусад хэрэгцээгээ хангаж чадахуйц түрээсийн үнэ өртөгийг төлөх ёстой. Хэрэв түрээсэлж буй байр нь хувийн эзэмшлийнх бол төрөөс тухайн байрны түрээсийг татаас хэлбэрээр олгож болох юм.

- ❑ Байр нь хангалттай тайлбайтай байх ёстой бөгөөд хэт олон хүн шавах ёсгүй. Газар болгонд стандарт нь ялгаатай байж болох ч, НҮБ-ын Суурьшлын байгууллагын үзүүлэлтээр бол нэг өрөөнд гурваас олон хүн амьдрахыг сайшаадаггүй юм.
- ❑ Шинээр суурьшсан орон байр, газар нь хүмүүс ажилдаа явах, сургууль, эрүүл мэнд бусад нийгмийн үйлчилгээнд ойр байх ёстой. Нийтийн тээврийн үйлчилгээ авах хэрэгтэй бол нийтийн тээвэр нь сааталгүй, үнийн хувьд боломжийн байх ёстой. Шинэ орон байрыг хогийн цэг дээр эсвэл түүний ойролцоо, үйлдвэрийн хаягдал хадгалдаг, байгалийн гамшигт байнга өртдөг, эсвэл бохирдолтой, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болох газарт барьж болохгүй.
- ❑ Хүмүүсийн урьд нь амьдарч байсан газар байгалийн гамшиг, эсвэл бусад хүчин зүйлээс болж тусгаарлагдсан, аюултай гэж тооцогдсоноос бусад тохиолдолд шинээр суурьших газар нь хуучин газраас холгүй байх ёстой.
- ❑ Шинэ орон байр, суурьшлын газар нь арьс өнгөөр ялгаварлах нөхцлийг бүрдүүлэх ёсгүй бөгөөд өртөж буй хүмүүсийн соёлын хэрэгцээнд нийцэх ёстой
- ❑ Шилжин суурьшснаар хүмүүс сонгуульд оролцох гэх мэт олон нийтийн үйл явцаас хоцрох, эсвэл нийгмийн үйлчилгээгээ авч чадахгүй байх нөхцөл бүрдүүлэхгүй байхад орон нутгийн захиргаа анхаарахч тэдгээр хүмүүст шинэ харьяалалдаа бүртгүүлэх, сонгуулийн эрхээ эдлэх, шинэ бичиг баримттай болоход нь туслах хэрэгтэй.
- ❑ Өнчин хүүхэд, эсвэл хүүхдээр толгойлуулсан өрх гэр байгаа тохиолдолд хүүхдийн эрхийг хамгаалахад онцгой анхаарах хэрэгтэй. Хүүхдийн төлөө байгууллага, халамжийн газар, төрийн бус байгууллага, орон нутгийн төлөөлөл гэх мэт хүүхдийн эрх хамгаалах байгууллагуудыг дайчилж хамгийн боломжийн нөхцлийг байдлыг нүүлгэн шилжүүлэлтэнд өртсөн хүүхдэд олгох хэрэгтэй.

# НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТЭНД ӨРТСӨН ХҮМҮҮСИЙГ ӨӨР ОРОН БАЙРААР ХАНГАХ, ШИНЭ ГАЗАРТ ШИЛЖИН СУУРЬШИХ БОЛОМЖУУДЫГ ҮНЭЛЭХ НЬ

Зөвшилцөх үйл явцын тухай бүлэгт өгүүлснээр орон нутгийн захиргаанаас шинээр шилжин суурьших газрын талаар бүх мэдээллийг хүмүүст өгч нүүлгэн шилжүүлэлтэнд өртөж буй хүмүүстэй боломжуудын талаар сайтар зөвлөлдөх ёстой. Зөвшилцөлд үйл явцад идэвхтэй оролцохын тулд хүмүүс санал болгож буй газар, эсвэл орон байрыг биеэр очиж үзэх бололцоотой байх хэрэгтэй. Орон нутгийн захиргаа нүүлгэн шилжүүлэлтэнд өртөж буй хүмүүсийн санал болгож буй газар, боломжуудыг харгалзан үзэх хэрэгтэй.

Хүмүүсийг шинээр суурьшуулах, боломжийн байр сууцаар хангах асуудлыг шийдэхдээ засаг захиргааны зүгээс маш өргөн хүрээнд сэтгэх нь зайлшгүй чухал юм. Ихэнхдээ хүмүүсийг хотын зах руу нүүлгэх явдал ажиглагддаг бөгөөд хүмүүс ажлын байр болон бусад үйлчилгээнээс холдох, зарим тохиолдолд арьс өнгөөр ялгаварлах тохиолдол ч үүсдэг. Энэ нь нэн сөрөг нөлөөтэй учир ажил олохын тулд буцаад хот руу нүүж, нийгмийн хөрөнгийг нэгдтэгэхэд хүрдэг. Тийм учраас, засаг захиргаанаас хүмүүстэй тэдний орон байрны хэрэгцээний талаар зөвлөлдөж, боломжуудыг нягт судлах хэрэгтэй. Шинээр суурьших газар, орон байрны загвар, засвар үйлчилгээний ажлыг хариуцаж буй архитекторч, зураг төслийн хүмүүстэй тухайн хүмүүсийг уулзуулж, санал авч болох юм.

5

Засаг захиргаанаас дэвшүүлэх арга хэмжээний нэг нь хоосон, эсвэл ашиглагдаагүй, аливаа нэгэн эзэмшилгүй, хотод ойрхон барилга байшингуудыг засварлах явдал байж болно. Түүнчлэн өртөг багатай барилга барих, эсвэл түрээсийг төлөх маягаар асуудлыг шийдвэрлэж болно. Хэрвээ тухайн төсөлд хувийн өмчлөгч оролцох тохиолдолд, засаг захиргааны зүгээс тухайн орон байрны тохижилт, аюулгүй байдал, хүмүүст шударга, эрх тэгш байдлаар хандаж буй эсэх, нүүлгэн шилжүүлэлт, суурьшилттай холбоотой асуудлуудыг бүрэн тусгасан эсэхэд анхаарал тавих ёстой.

Нөлөөлөлд өртсөн хүмүүс өөрсдийн хэрэгцээ шаардлагын талаар хамгийн сайн төсөөлөлтэй байдаг учраас тэдэнтэй нягт зөвлөлдөж ажилласнаар ийм мэдээлэл олж авах боломж бүрдэнэ.

Жишээ нь, зарим тохилдолд хүмүүс засаг захиргаанаас барилгын материалыг боломжийн үнээр нийлүүлвэл, шинэ орон байраа өөрсдөө бариад, улсаас ус, бохир, цахилгааны хангамжийг шийдээд өгвөл, үйлчилгээнийхээ хөлсийг төлөх санал гаргаж болзошгүй. Маш олон хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх үед засаг захиргааны зүгээс нөлөөллийн үнэлгээ, суурь судалгааг хийж нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг гаргах ёстой.

## ТҮР ОРОН БАЙР

Нүүлгэн шилжүүлэлт эхлэхээс өмнө нөхөн олговор, шинээр суурьших асуудлыг шийдвэрлэсэн байх ёстой. Хүмүүст түр оршин суух байр зөвхөн зайлшгүй тохиолдолд, тухайлбал тухайн хүмүүсийн орон байрыг сайжруулахдаа хүн амьдрах аргаар томоохон засвар үйлчилгээ хийж байгаа, эсвэл тухайн амьдарч буй газар, орчин нь хүний эрүүл мэнд аюулгүй байдалд заналхийлж буй үед богино хугацаанд нүүлгэх асуудал тулгарахад олгох ёстой. Хүмүүс, тэдний төлөөлөгчдөд нөхцөл байдлыг сайтар тайлбарлах хэрэгтэй.

Орон нутгийн захиргаа тухайн хүмүүс түр оршин суух орон байранд аль болох богино хугацаанд амьдарч, дараа нь урт хугацаанд амьдарч болох орон байраар хангахад анхаарна. Нүүлгэн шилжүүлэлт тухайн хүмүүсийн амьдрал, ялангуяа боловсрол, ажил, эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээнд тасалдал аль болох бага гарах талаас нь анхаарч ажиллах ёстой.

Түр оршин суух байр шаардлага хангасан орон байртай байх эрхэд заагдсан нөхцлүүдийг хангах ёстой.

Урт хугацаанд оршин суух байрны асуудал хэрхэн шийдвэрлэгдэж байгаа талаар орон нутгийн захиргаа байнга мэдээлэл өгөх ёстой бөгөөд захиргааны болон шүүхийн үйл явцаар шийдвэр гаргах мэдээлэл, боломжуудыг олгох ёстой.

5

ОИН.МН  
СУДАЛГААНЫ САН

# НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙГ ЯВУУЛАХ НЬ

«Нүүлгэн шилжүүлэлт хүмүүсийн амьд явах, аюулгүй байх эрхийг зөрчих байдлаар явагдах ёсгүй. Нүүлгэн шилжүүлэлтийн үйл явцад эмэгтэйчүүд хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалд өртөгдөхгүй байх, хүүхдийн эрхийг хамгаалахад төр тодорхой алхамууд хэрэгжүүлэх ёстой.»

Хөгжилд чиглэсэн нүүлгэн шилжүүлэлт хийх НҮБ-ын үндсэн зарчим болон журам, 47 дугаар зүйл

Шаардлагтай арга хэмжээнүүдийг авч, нүүлгэн шилжүүлэхээс өөр аргагүй тохиолдолд, өртөж буй хүмүүсийн эрхийг хүндэтгэх ёстой бөгөөд хүч хэрэглэвэл тэр нь зайлшгүй шаардлагатай, тэнцвэртэй, олон улсын хүний эрхийн стандартын дагуу байгааг төрөөс баталгаажуулах ёстой.

Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн асуудал эрхэлсэн НҮБ-ын хороо, “Нүүлгэн шилжүүлэх үндэслэл байгаа тохиолдолд олон улсын хүний эрхийн хуулийн холбогдох зүйл заалтын дагуу зохион байгуулж, тэнцвэртэй шалтгаантай байх зарчмыг баримтлах ёстой” гэжээ. НҮБ-ын хороо “Түүнчлэн нүүлгэн шилжүүлэлтийн үед төрийн албан хаагчид эсвэл тэдний төлөөлөгчид байлцах ёстой, нүүлгэн шилжүүлэлтийг удирдаж байгаа хүмүүс өөрийг нь таних биеийн байцаалттай байх ёстой бөгөөд нүүлгэн шилжүүлэлтийг цаг агаарын таагүй нөхцөл, эсвэл харанхуй шөнө хийж болохгүй гэж заажээ.

“Нүүлгэн шилжүүлэлтийн үед хуулийн дагуу хүч хэрэглэх тохиолдол гарвал тэр нь шаардлага, тэнцвэртэй байдлын зарчмыг дагах ёстой”. Мөн хууль сахиулагч галт зэвсэг, хүч хэрэглэх үндсэн зарчмыг дагаж, “тухайн улсын болон орон нутгийн зарчим, олон улсын хууль сахиулах болон хүний эрхийн стандартын дагуу явагдах ёстой”.

“Нүүлгэн шилжүүлэлт цаг агаарын таагүй нөхцөлд, харанхуй шөнө, тэмдэглэлт баяр наадам, шашны ёслол, сонгуулийн өмнө, сургуулийн шалгалт эхлэх эсвэл дууссаны дараахан явагдах ёсгүй”.

Нүүлгэн шилжүүлэлтийн үед нэг ч хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүд шууд болон шууд бус халдлага, хүчирхийллийн бусад хэлбэрт өртөгдөхгүй байх, нураах, тонох гэх мэт санаатайгаар устгах үйл ажиллагаанд хүмүүс өмч хөрөнгөө устгуулахгүй байх, үл тоомсорлох, нийтээрээ нэг хүнийг санаатайгаар шийтгэх явдлаас сэргийлэх ёстой. Үлдээхээс өөр аргагүйд хүрсэн өмч хөрөнгийг эвдэн сүйтгэхээс хамгаалж, хүчээр, хууль бусаар эзэмших, авах, ашиглахыг таслан зогсоох ёстой.”

Нүүлгэн шилжүүлэлт хийснээр ямар нэгэн хүний эрх зөрчигдөхөөс сэргийлэхийн тулд өртөж буй хүмүүстэй засаг захиргааны зүгээс байнга холбоотой байж, нүүлгэн шилжүүлэлтэнд бэлэн эсэхийг судлах хэрэгтэй. Засаг захиргааны зүгээс өртөж уй хүмүүстэй уулзах, эсвэл олон нийтийн хурал хийх замаар нүүлгэн шилжүүлэлтийн үйл явц, түүнтэй холбоотой асуудлаар мэдээлэл түгээж, нүүлгэн шилжүүлэлт болох өдөр тусламж, үйлчилгээ хэрэгтэй хүний тоог гаргана.

Орон нутгийн захиргаа нүүлгэн шилжүүлэлтийн үйл явцыг хүмүүст тайлбарлаж, энэ үйл явцад оролцох төр, хувийн хэвшлийн албан тушаалтнууд, тэдний үүргийн талаар мэдээлэл өгөх ёстой.

Хүмүүс өөрийнхөө байшинг нураах, эсвэл хог хаягдлаа цэвэрлэх нөхцөл гаргахгүй байхад төрөөс анхаарах хэрэгтэй. Харин хүмүүс өмч хөрөнгө эвдэхээс сэргийлэх, барилгын зарим материалыг дахин ашиглах зорилгоор өөрсдөө нураах санал гаргавал, энэ нөхцөл хамаарахгүй.

Нүүлгэн шилжүүлэхдээ газрыг чөлөөлөх зорилгоор галдан шатаахыг хориглоно. Хэрэв бульдозер ашиглавал тухайн газрыг хашиж, хүмүүс, тэдний өмч хөрөнгө, хувийн мал, амьтан зэргийг холдуулж аюулгүй газар аваачсаны дараа ажиллуулах хэрэгтэй. Орон нутгийн захиргаанаас хүмүүст эд хогшлоо шинэ газар, эсвэл орон байрандаа зөөхөд нь тусалж унаагаар хангах хэрэгтэй. Хөдөлгөөний бэрхшээлтэй, эсвэл хөдөлгөөнгүй, хүнд өвчтэй, ахмад настан, жирэмсэн эмэгтэйчүүд, бага насны олон хүүхэдтэй, эсвэл нярай хүүхэдтэй хүмүүст тусгайлсан тусламж үзүүлэх хэрэгтэй.

МОНГОЛ  
СҮДАЛГААНЫ САН

6

Нүүлгэн шилжүүлэлтэнд өртсөн хүмүүс ялангуяа ахмад настан, хүүхдүүдийг шинэ газар, орон байрандаа очсоны дараа хуучин орон байрыг нураах ажлыг хийнэ.

Нүүлгэн шилжүүлэлтийн туршид гал унтраах, түргэн тусламжийн үйлчилгээ ойр байх ёстой.

Нүүлгэн шилжүүлэлтийн явцад хүний эрхийн зөрчил гарахаас сэргийлэхийн тулд орон нутгийн захиргаа хараат бус ажиглагчдыг нүүлгэн шилжүүлэлтийн үед ажиллуулах ёстой.

Нүүлгэн шилжүүлэлтэд ажиллаж буй бүх хүнд /эрэгтэй, эмэгтэй ялгаагүй/ жендерийн мэдрэмжтэй сургалт явуулах ёстой.

Нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой санал гомдлыг бүртгэх цэг ажиллаж байгааг бүх хүнд мэдээлэх үүргийг засаг захиргаа хүлээнэ.

# ШИНЭЭР СУУРЬШИХ ҮЙЛ ЯВЦЫГ ХЯНАХ НЬ

«Төрөөс өөрийн хууль эрх зүйн, хяналтын хүрээнд болж өнгөрсөн нүүлгэн шилжүүлэлт, тэдгээрийн урт хугацааны үр дагаврын талаар тоо, чанарыг үнэлгээг идэвхтэй хийх ёстой. Тухайн туршлагад үндэслэсэн сайн туршлага, сургамжуудын талаар хяналт үнэлгээний тайлан, баримт бичгүүдийг нийтийн хүртээл болгох хэрэгтэй.»

Хөгжилд чиглэсэн нүүлгэн шилжүүлэлт хийх НҮБ-ын үндсэн зарчим болон журам, 69 дүгээр зүйл

Нүүлгэн шилжүүлэлт өнгөрсний дараа орон нутгийн захиргаа шинээр суурьших газар, орон байр нь үндэсний болон олон улсын хүний эрхийн стандартыг хангаж буй эсэхэд хяналт чухал үүрэгтэй.

Шинээр суурьшсан газар, орон байр нь шаардлага хангасан орон байртай байх эрхийн гол зарчмуудад нийцэж буй эсэхэд орон нутгийн захиргаа байнгын хяналт тавих ёстой. Асран хамгаалагчгүй хүүхэд, хүүхэд толгойлсон өрхийн хувьд нийгмийн халамж. Хүүхдийн төлөө байгууллагатай хамтарч орон нутгийн захиргаа тэдний амьжиргааны, ерөнхий байдлыг хянах ёстой.

Шинэ газар суурьшсантай холбоотойгоор хүмүүс бусад эрхээ эдлэхэд нь бэрхшээл тулгарч байгаа эсэхэд мөн хяналт тавина. Тухайлбал боловсрол, ажил хөдөлмөр, эрүүл мэндийн үйлчилгээ авч чадаж байгааг анхаарна.

ОИХ.МН  
СУДАЛГААНЫ САН

7

Шинээр олгосон орон байртай холбоотой санал гомдлоо илэрхийлэх механизмуудын талаар хүмүүст мэдээлэл өгөх ёстой.

Санал гомдол хүлээж авах, шийдвэрлэх албан хаагч, эсвэл төлөөлөгчийг орон нутгийн захиргаанаас томилох хэрэгтэй. Томилолт шинээр суурьших үйл явц олон улсын хүний эрхийн стандартыг зөрчиж буй тохиолдолд хуулиар шийдвэрлэх гарцыг хаах ёсгүй.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

# АШИГЛАСАН БАРИМТ БИЧИГ

Иргэний болон улс төрийн эрхийн тухайн олон улсын Пактын 17 дугаар зүйл, Хүүхдийн эрхийг хамгаалах НҮБ-ын Конвенцийн 16/1/, 27/4/ дүгээр зүйл, Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах олон улсын конвенцийн 5/e/ зүйл, Эмэгтэйчүүдийг явлагаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах НҮБ-ын конвенцийн 14/2/ зүйл, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах НҮБ-ын конвенцийн 9, 28 дугаар зүйл: Бүсийн түвшинд шаардлага хангасан орон байртай байх эрхийн Европын хуулийн шинэчилсэн найруулгын 16, 31 дүгээр зүйл /Европын нийгмийн хуулийн 16 дугаар зүйл/, Европын Хүний эрхийн конвенцийн 8/1/ дүгээр зүйл, Хүний болон хүмүүсийн эрхийн тухай Африкийн дүрмийн 14, 16, 18/1/-д, Хүүхдийн нийгмийн хамгааллын эрхийн тухай Африкийн дүрмийн 18, 20 дугаар зүйл, Хүний болон Хүмүүсийн эрхийн тухай Африкийн дүрмийн эмэгтэйчүүдийн эрхийн протоколын 16 дугаар зүйл: Хүний эрхийн тухай Америкийн конвенцийн 11/1/, 21/1/, 26 дугаар зүйлд заажээ. Хэдийгээр Европын Хүний эрхийн конвенцийн Европын Нийгмийн дүрэм /1961/, Америкийн Хүний эрхийн конвенци, Африкийн Хүний эрхийн дүрэмд шаардлага хангасан орон байртай байх эрхийг тухайлан дурьдаагүй ч, хувийн өмчтэй байж, эд хөрөнгөө тайван замаар ашиглах, хувийн нууц, гэр бүлээ хамгаалуулах эрхийн хүрээнд төрөөс шаардлагад

нийцсэн орон байртай байх эрхийг хамгаалсаныг энэхүү баримт бичгүүдийн хэрэгжилтийг хянадаг байгууллагууд тодруулжээ.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн асуудал эрхэлсэн НҮБ-ын хороо албадан нүүлгэлт “хувь хүмүүс, гэр бүл, бүлэг хүмүүсийг ямар нэгэн тохирсон эрх зүйн болон бусад хамгаалалтгүйгээр, тэдний зөвшөөрөлгүй гэрээс нь, эсвэл амьдарч буй газраас түр эсвэл бүр мөсөн нүүлгэхийг хэлнэ” гэж заажээ. НҮБ-ын хорооны Ерөнхий Зөвлөмж □ 7: Шаардлага хангасан орон байртай байх эрх /11.1 зүйл/: Албадан нүүлгэлт, 3 мөр, /1997 оны 5 сарын 20-ны 16 дугаар хуралдаан/, E/1998/22

НҮБ-ын хороо, Ерөнхий зөвлөмж □ 4: Шаардлага хангасан орон байртай байх эрх /11.1 зүйл/, 18 мөр /1991 оны 12 сарын 13-ны 6 дугаар хуралдаан/, E/1992/23

НҮБ-ын хороо, Ерөнхий зөвлөмж □ 7, 8 мөр

НҮБ-ын хороо, Ерөнхий зөвлөмж □ 4, 8/a/ мөр

Хүний эрхийн хорооны дүгнэлт зөвлөмж: Кенийн Хүний эрхийн хороо, CCPR/CO/83/KEN, 2005 оны 4 сарын 29, 22 мөр

161/2000 дугаарын захиа, U.N.Doc. CAT/C/29/D/161/2000 (2002)

Хүний эрхийн шийдвэр эрхэлсэн НҮБ-ын Хороо, 1993/77, 1 мөр

Хөгжилд чиглэсэн нүүлгэлт ба суурьшилтын талаарх НҮБ-ын Үндсэн журам ба дүрэм /Ерөнхий зарчим/, хавсралт 1, UN DOC, A/ HRC/4/18

Үндсэн зарчим, Зарчим 44, 55, 56

НҮБ-ын хороо, Ерөнхий Зөвлөмж  
□ 7, 9 мөр

Үндсэн зарчим, Зарчим 38

НҮБ-ын хороо, Ерөнхий Зөвлөмж  
□ 7, 13 мөр

Үндсэн зарчим, Зарчим 41

Уугуул иргэдийн эрхийн тухай  
НҮБ-ын тунхаглал 2007, 26 зүйл

Уугуул иргэдийн эрхийн тухай  
НҮБ-ын тунхаглал 2007, 10, 32/2/  
зүйл

Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах НҮБ-ын хороо, Ерөнхий Зөвлөмж □ 23:  
Уугуул иргэд /1997/08/18-ны 51 дүгээр хуралдаан/ Хавсралт 5, A/52/18. Мөн Хүний Эрхийн тухай

НҮБ-ын хорооны шийдвэрийг харна уу

I/A HR Court8 Saramaka People v. Suriname, Series C (no. 172) (2007)

Үндсэн зарчим, Зарчим 56 /j/

НҮБ-ын хороо, Ерөнхий Зөвлөмж  
□ 7, 13 мөр

НҮБ-ын хороо, Ерөнхий Зөвлөмж  
□ 7, 15 мөр

НҮБ-ын хороо, Ерөнхий Зөвлөмж  
□ 4, 17/a/ мөр

Үндсэн зарчим, Зарчим 41

НҮБ-ын хороо, Ерөнхий Зөвлөмж  
□ 7, 13 мөр

Үндсэн зарчим, Зарчим 60

НҮБ-ын хороо, Ерөнхий Зөвлөмж  
□ 7, 14 мөр

Үндсэн зарчим, Зарчим 47-50

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

# ТЭМДЭГЛЭЛ



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

# ҮҮРГЭЭ МЭД

## АЛБАДАН НҮҮЛГЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ГАРЫН АВЛАГА

Хүн болгон гаардлага хангасан оррн байраар хангагдах эрхтэй бөгөөд улс болгоны үндэсний болон орон нутгийн засаг захиргаа, удирдлагууд энэхүү эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх үүрэгтэй билээ. Орон сууцыг төлөвлөх, барих ажилд хамгийн түрүүнд орон нутгийн захиргаа оролцдог байна. Түүнчлэн албадан нүүлгэн шилжүүлэлтийн хамгийн голлох шалтгаан болох дэд бүтэц, хотын дахин төлөвлөлт буюу зохион байгуулалт, томоохон бүтээн байгуулалт гэх мэт үйл ажиллагааг орон нутгийн захиргаа удирдаж явуулдаг билээ.

Албадан нүүлгэлт буюу хүмүүсийг хүсээгүй байхад нь оршин сууж буй орон байр, газраас нь ямар нэгэн хууль зүйн болон бусад хамгаалалтгүйгээр нүүлгэх явдал нь олон улсын хүний эрхийн зөрчил болдог.

Нүүлгэн шилжүүлэлтийн шалтгаанаас үл хамааран, түүнийг гүйцэтгэх ажилд орон нутгийн захиргаа шууд буюу шууд бусаар оролцохоос өөр аргагүй болдог. Тийм учраас, иргэд албадан нүүлгэлтэнд өртөхгүй байх, шаардлага хангасан орон байраар хангагдах эрхийг сахин хамгаалахад орон нутгийн захиргаа эерэг нөлөөтэй оролцож болох юм.

Эмнести интернашнл байгууллагын судалгаан дээр үндэслэн энэхүү гарын авлага нь гаардлага хангасан орон байраар хангагдах эрхийг хамгаалахад төрийн ажилтнууд болон төрийн өмнөөс үүрэг гүйцэтгэж буй хүмүүст туслах зорилготой юм. Гарын авлага олон улсын хүний эрхийн холбогдох зүйл заалт, стандартыг танилцуулаад зогсохгүй, нүүлгэн шилжүүлэлтийг төлөвлөх, гүйцэтгэх үед авах ёстой арга хэмжээний талаар танилцуулсан байна.

**ЭМНЕСТИ  
ИНТЕРНЭШНЛ**



УИИМ  
СУДАЛГААНЫ ГАН